Хэрэггvй файлуудыг яаж устгах вэ?

Хатуу дискэнд бичигдсэн хэрэггvй файлуудыг байнга устгаж цэвэрлэж байх шаардлагатай. Юуны тvpvvнд устгасан файл, директоруудыг хадгалдаг Recycle Bin-г шалган файлууд байвал цэвэрлэх хэрэгтэй.

Yvний тулд Windows системийн дэлгэцнээс Recycle Bin гэсэн тэмдгэн дээр хулганы заалтуурыг байрлуулан баруун талын товчлуур дээр дарж, Empty Recycle Bin командыг сонгоно.

Дараагийн шатанд хэрэглэгддэггүй программуудаа хатуу дискнээс арилгах хэрэгтэй. Дурын программыг суулгах явцад <u>Windows</u> vйлдлийн систем файлуудыг энд тэнд тараан байрлуулдаг учраас программыг гараар арилгахад төвөгтэй. Аливаа программыг устгахдаа тvvнийг хатуу дискнээс арилгадаг тусгай утилит программ буюу Uninstall-г ашиглах нь зvйтэй. Ихэнх программууд суулгасан программаа буцаж арилгах Uninstall утилиттэй ирдэг.

Windows 95/98 vйлдлийн системийн программуудыг Start->Settings->Control Panel командаар нээгдэх цонхны *Add/Remove Programs* командыг сонгон устгах боломжтой. Тухайн программыг арилгадаг утилитыг ашигласнаар тэр нь зөвхөн программын файлуудыг устгаад зогсохгvй системийн чухал файлуудтай холбогдсон холбоог тасалдаг.

Хатуу дискийг хэрхэн шалгах вэ?

Файл хуваарилалтын хvснэгт буюу FAT-д гэмтэл гарснаас vйлдлийн болон файлын систем гацаж, хатуу дискэнд программын алдаа гардаг. Диск шалгадаг программ нь хатуу дискэн дэх алдааг илрvvлэх, боломжтой бол алдагдсан мэдээллийг сэргээх чадвартай. Дискний уншигч толгой нь тухайн хэсэгт ямар бит бичигдсэнийг тодорхойлж чадахгvй болсон veд аппаратын алдаа гардаг. Файлын систем ийм эвдрэлтэй хэсгvvдийг тэмдэглээд, тэдгээрийг цаашид мэдээлэл хадгалахад ашиглахааргvй болгодог.

Хатуу дискийг шалгах vнэтэй программууд байдаг боловч Windows 9x vйлдлийн системтэй цуг ирдэг <u>Scan Disk</u> программ хангалттай. Vvнийг ажиллуулахдаа Start->Programs->Accessories->System tools команд сонгоно. Хатуу дискийг эхний удаа автоматаар алдаа засахаар тохируулж шалгах хэрэгтэй. Энэ vйлдэл хатуу дискний багтаамжаас хамааран харилцан адилгvй хугацаанд vpгэлжилнэ. Хатуу дискийг сар тутам шалгаж байх хэрэгтэй.

Хатуу дискийг хэрхэн vp ашигтай ашиглах вэ?

Файл нээх, шинэчлэх, хуулах, зөөх, устгах зэрэг vйлдлvvдийг хийх явцад vйлдлийн систем тvvнийг хатуу дискэнд хэсэг хэсгээр нь салгаж бичдэг. Иймээс энэ жижиг хэсгvvд хатуу

дискээр нэг тарж замбараагvй байрладаг байна. Тvvнийг фрагментац гэдэг бөгөөд тvvний хэмжээ их байх тусам дискийн гэмтэх магадлал ихэсдэг. Энэ алдаанаас сэргийлж, файлын тарж бутарсан жижиг хэсгvvдийг эмхэлж нэг дор байрлуулдаг тусгай программууд байдаг ба тэдгээрийг дефрагментацийн программууд гэнэ. Тухайн дискийн фрагментацаас хамаарч энэ vйлдэл хэдхэн минутаас хагас цаг хvртэл хугацаанд vpгэлжилнэ. Дефрагментацийн vйлдэл хийсний дараа компьютерт файлыг дуудаж ажиллуулах, хатуу диск pvv хуулах зэрэг vйл ажиллагаанууд харьцангуй богино хугацаанд хийгддэг. Учир нь хатуу дискний уншигч толгойн нааш цааш хөдлөх хөдөлгөөн эрс багасдаг. <u>Windows</u> орчинд ажилладаг дефрагментацийн хялбархан программ байдаг бөгөөд Start->Programs->Accessories->System tools->Disk Defragmenter командаар ажиллуулна. Компьютерийнхээ найдвартай хурдан ажиллагааг хангахын тулд энэ программыг сар бvр ажиллуулж байх шаардлагатай

Файлуудын нөөц хувийг хаана яаж хадгалах вэ?

Чухал хэрэгтэй файлуудын нэг хувийг хатуу дискэнд, нөөц хувийг нь зөөврийн төхөөрөмжинд хадгалах хэрэгтэй. Файл, директоруудыг нөөцлөх энэ үйлдлийг Backup гэж нэрлэдэг. Компьютерийнхээ хатуу дискэн дээрх файлуудыг хагас жил тутам нэгээс доошгvй удаа нөөцлөж байвал зохино.

Ийм бүрэн нөөц хувийг багтаамж сайтай зөөврийн хатуу дискэнд эсвэл Zip дискэнд хадгалахад тохиромжтой. Мэдээллийг ингэж хадгалахын зэрэгцээ тухайн үед хэрэглэж байгаа мэдээллийнхээ талаар анхаарал тавихгүй өнгөрч болохгүй.

Энэ зорилгоор хатуу дискэнд сvvлийн veд хийгдсэн өөрчлөлт бvрийг хуулбарлан хадгалах инкремент аргыг хэрэглэдэг. Мэдээллийн инкремент хувийг шинэчлэгдэж буй файл хэр зэрэг ашиглагддагаас хамааран 7 хоногт нэг удаа хийх хэрэгтэй.

Тухайлбал: 100 <u>Mb</u> багтаамжтай Zip дисктэй бол хатуу дискэн дээрээ 100 мегабайтын хэмжээтэй тусгай хэсэг vvcгэнэ. Ажлын өдөр дуусмагц тэр хэсэг дэх мэдээллийг Zip диск рvv зөөхөд л хангалттай.

Startup disk-г яаж бэлтгэх вэ?

Компьютерийн дурын эд анги эвдэрсэн тохиолдолд шинээр сольж болно. Харин хатуу дискэн дээр бичсэн мэдээллээ алдсан тохиолдолд танд бүхнийг эхнээс хийх шаардлага гарна. Үүний тулд хэдэн сар жил ч шаардагдаж магадгүй.

Ийм аюулаас урьдчилан сэргийлж хатуу дискээ хамгаалах хэрэгтэй. Юуны түрүүнд алдаа гарахад шалгадаг ачаалах диск болох *Startup disk* бэлтгэх нь зүйтэй. Ямар нэг шалтгаанаар

үйлдлийн ситемийг хатуу дискнээс ачаалахад энэ диск шаардагдана. Компьютерээ асаахгүйгээр дискээ сэргээх, шалгах зэрэг ямар ч үйлдэл хийж болохгүй тул аваарын ачаалах диск бэлтгэж авах нь зүйтэй.Дискийг бэлтгэхдээ Start->Settings->Control Panel->Add/Remove Programs руу орно. Vvний дараа гарч ирэх цонхон дахь цэснээс *Startup Disk* -г сонгон *Create Disk* товчлуурыг дарна. Таньд 1,44 Mb хэмжээ бүхий нэг уян диск байх шаардлагатай.

Шинээр хатуу дискийг хэрхэн суурилуулах вэ?

Компьютерийн тань хатуу дискний багтаамж хvрэлцэхгvйн улмаас сул зай гаргах гэж "компьютерийнхээ ёроолыг нь хvртэл ухаж" бvхимдах явдал бишгvй л гардаг байх. Заримдаа шаардлагатай хэрнээ тухайн veд хэрэглэгдэхгvй байгаа программуудаа хvртэл харамсан байж арчих явдал ч олонтаа тохиолддог.

Их хэмжээний сул зай ашиглах шаардлагатай хэрэглэгчид ялангуяа график зураг, аудио ба видео файлтай байнга ажилладаг хүмүүст 2 GB-с дээш багтаамж бүхий EIDE диск шаардагддаг. Иймээс шинээр компьютертээ хатуу диск суурилуулах замаар дискийнхээ багтаамжийг өөрийн ажлын шаардлагад тохируулан ихэсгэж болно.

Гэхдээ 1994 оноос өмнө vйлдвэрлэгдсэн компьютерvvд 528 MB-с дээш, 1996 оноос өмнө vйлдвэрлэгдсэн компьютерvvд 2.1 GB-с дээш багтаамж бvхий дисктэй зохицдоггvйг анхаарах хэрэгтэй. Харин сvvлийн veийн компьютерvvдийн хувьд наад зах нь 6 GB хvртэлх багтаамж бvхий дисктэй ажиллах чадвартай.

Энэ нь компьютерийн бусад vзvvлэлтvvдээс хамаарна.EIDE дисктэй хамт ирдэг программ хангамж нь дээрх бэрхшээлийг шийдвэрлэхэд тодорхой vvрэг rvйцэтгэдэг боловч компьютерийнхээ BIOS-д анхаарах нь чухал.Компьютерт тань программчлагдах боломжтой BIOS суусан байвал vйлдвэрлэсэн пvvc, компанийнх нь вэб хуудсаас шаардлагатай программ хангамжийг ачаалан ажиллуулах замаар сэргээж болно. Эсрэг тохиолдолд BIOS микросхемийг шинээр худалдан авахаас өөр аргагvй. EIDE диск төхөөрөмжvvд нь өгөгдлийг 33 Мбит/с хурдтай дамжуулах *Ultra DMA/33* интерфейстэй. Шинээр суулгах хатуу диск нь хуучнаасаа багтаамж болон өгөгдөл унших, дамжуулах хурдаараа их байх шаардлагатай. Иймээс хуучин дискээ D, шинээр суулгах дискээ C байхаар тохируулах хэрэгтэй. Хуучин диск дээрх мэдээллvvдээ тусгай утилит ашиглан хуулан авч болно. Хатуу дискийг компьютерт суулгахдаа:

Компьютерт байгаа хуучин дискээ шалгана. Start->Programs->Accessories->System
 Tools-> Scan Disk командаар Scan Disk программыг ачаалан ажиллуулаад, дараа нь Start >Programs-> Accessories->System Tools-> Disk Defragmenter командаар дефрагийг хийнэ.
 Шинэ төхөөрөмжийг ажилд бэлтгэхэд ачаалагч диск шаардагдвал уян диск төхөөрөмжид

дискээ хийгээд vндсэн дэлгэцэнд байрлах "My Computer" гэсэн цонхыг сонгож 2 дарна. Нээгдэх цонхноос 3 1/2 Floppy (A:) цонхыг идэвхжvvлээд ерөнхий цэснээс File-г сонгож Format командыг дарна. Улмаар нээгдэх Format харилцах цонхны *Format Type* бvлгээс Full, *Other Options* бvлгээс Copy Systems Files товчлууруудыг тус тус сонгоно. Компьютерээ дахин ачаалсны дараа A: диск төхөөрөмжид хатуу дискийг ажилд бэлтгэхэд шаардагдах программ бvхий диск оруулахыг хvссэн мэдээлэл гардаг.

2. Компьютерээ унтрааж, тэжээлээс нь салгаад процессорынхоо тагыг нээнэ. Хатуу дискээ салгаж авалгvйгээр туузан болон тэжээлийн кабелийг диск төхөөрөмжөөсөө салгана. Туузан кабелийн захын улаан зураас нь яаж байрлаж байсныг тогтоох шаардлагатай. Туузан кабельдаа шинээр хатуу диск холбох хоёрдогч vзvvр мөн компьютерт тэжээлийн сул кабель байгаа эсэхийг мэдэх хэрэгтэй. Байхгvй бол хоёр vзvvр бvхий туузан кабель болон тэжээлийн Y хэлбэрийн салаалагч худалдан авах шаардлагатай. Хуучин дискийг заавал авах шаардлагатай бол тvvн дээр байрлах электрон элементvvдийг гэмтээлгvйгээр болгоомжтой авах хэрэгтэй.

3. Хэрэв ерөнхий кабелиар хоёр EIDE төхөөрөмжийг холбосон бол тэдгээрийн нэг нь vндсэн (Master), нөгөө нь нэмэлт (Slave) байхаар тохируулсан байх шаардлагатай. Хатуу дискэн дээр холболтын схем бvхий цаас наалттай байдаг бөгөөд хэрэглэгчийн зааврыг ашигласан ч болно. Шинэ дискийг Master, хуучин дискийг Slave болгон тохируулна.

4. Хэрэв хоёр дахь алхмыг биелvvлэх veд хуучин хатуу дискээ сугалж авсан бол буцааж хийнэ. Шинэ хатуу дискээ хуучин дисктэйгээ аль болохоор ойрхон байрлуулан суулгах хэрэгтэй. Учир нь кабелийн vзvvр төхөөрөмжvvдэд хоёуланд нь хvрэхээр байх хэрэгтэй. Дискнvvддээ кабелиар холбоно. Туузан кабелийн улаан зураас нь тэжээлийн нvдний нэгдvгээр хөлд (контакт) холбогдсон байх шаардлагатай. Зарим кабелиудад буруу холболтоос сэргийлсэн тусгай тvлхvvp байдаг.

Системийн платад холбогдсон кабель утаснуудаа сайтар нягтлан шалгана. Кабелиа Primary EIDE нvдэнд холбоод, улмаар тэжээлийн кабелийг диск төхөөрөмжтэйгээ холбоно.

5. Компьютерээ асаагаад, ачаалалтын эхний veд компьютерийн параметрvvдийг тохируулах Setup программд орж, нэг болон хоёрдугаар байгууламжийн хувьд Auto горим сонгогдсон эсэхийг шалгана. Систем өөрөө диск төхөөрөмжvvдээ таниад шаардлагатай параметрvvдээ тогтоодог. Параметрvvдээ хадгалаад, ачаалалтын дискний тусламжтайгаар

компьютерээ дахин ачаална. Өгөгдөл хуулах программтай дискээ диск төхөөрөмжид хийгээд, программ ажиллуулах командыг сонгоно. Энэ команд нь ихэвчлэн дискийн хаягийн цаасан дээр бичигдсэн байдаг. Шинээр суулгах диск төхөөрөмжийнхөө параметрыг тодорхойлохдоо зааврыг мөрдөнө. Хуучин диск дээрх мэдээллийг шинэ диск рvv хуулна.

6. Утилитыг ажиллаж дууссаны дараа дискээ гаргаад компьютерээ дахин ачаална. Системийн тест болоод Windows vйлдлийн систем ачаалагдсаны дараа бvx программ хангамжууд зөв ажиллаж байгаа эсэхийг нь шалгаад, шинээр мэдээлэл бичихийн тулд хуучин дискээ форматлана. Yvний тулд vндсэн дэлгэцэнд байрлах **My Computers** цонхон дээр хоёр дарж, нээгдэх цонхноос форматлах хоёрдохь хатуу диск буюу D дискийг сонгоод хулганы баруун талын товчлуур дээр дарж, нээгдэх цэснээс Format командыг сонгоно.

Дискийн зайг хэмнэх арга Орчин үеийн компьютерийн гол үзүүлэлтүүдийн нэг нь хатуу дискийн багтаамж юм.

Өнөөдөр орчин үеийн өндөр үзүүлэлттэй компьютерээс гадна 486, 586 компьютерүүд ашиглагдсаар байна. Эдгээр компьютерийн хатуу дискүүд янз бүрийн хэмжээтэй байдаг бөгөөд, дискийн багтаамж их байх шаардлагатайг бага багтаамж бүхий дисктэй ажиллаж байхад илүү их мэдэрдэг билээ. Дискийнхээ сул зайг ихэсгэхийн тулд хэрэгцээгүй файлуудыг устгах, файлуудыг архивлах гэх мэт янз бүрээр оролддог. Энэ бүхнээс үүдэн дискний сул зайг ихэсгэх үр ашигтай арга байдаг болов уу гэсэн асуулт зүй ёсоор тавигдана.Юуны өмнө дискийн бүтцийн тухай товч танилцуулъя.

Уян ба хатуу дискийн бүтцийг доорх зурагт үзүүлэв.Энд Boot нь дискийн тухай мэдээллийг агуулах сектор, FAT (file allocation table) нь файл байршлын хүснэгт, Root нь файлын каталог, Partition table нь хуваалтын хүснэгт болно. Эдгээрээс FAT хүснэгтийг онцгойлон авч үзье. Дискийн файл бичигдэх хэсгийн хамгийн бага нэгж нь кластер юм. Кластер бүхэн өөрийн дугаартай байх бөгөөд файл бичигдсэн кластерийн дугаарыг (нэг файл нэг кластерт бичигдэхээс гадна хэд хэдэн кластерт бичигдэж болох ба энэ тохиолдолд файл бичигдсэн кластерийн гинжин дарааллыг) FAT агуулж байдаг. Кластерийн дугаарт FAT хүснэгтийн хичнээн бит зориулагдаж байгаагаас хамааран FAT 16, FAT32 файлын системтэй диск гэж нэрлэдэг. Үүнийг DOS, Windows үйлдлийн системийн сонгосон хувилбараас хамааруулан дискийг форматлах явцад систем өөрөө тогтоож өгдөг. Дискийн кластерийн тоог ихэсгэхийн тулд түүнийг дугаарлахад зориулагдах битийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Иймд FAT16-аас FAT 32 нь илүү олон кластерийг дугаарлах нь ойлгомжтой. Ихэнх компьютер нэг хэсгээс тогтох хатуу

дисктэй байдаг нь **Windows** үйлдлийн системийн хуучин хувилбартай ажиллах үед дискийн зайг маш их хэмжээгээр ашиггүй зарцуулдаг байна. **DOS, Windows** системийн өмнөх хувилбаруудад кластерийн хэмжээ хуваалтын хэсгийн хэмжээнээс хамаарч 2 Кбайтаас 32 Кбайтын хооронд байдаг байна. Хамгийн бага хэмжээтэй ямар ч файл байсан нэг кластерт бичигдэх бөгөөд кластерийн үлдэх хэсэг нь ашиглагддаггүй. Хэрэв хатуу диск үй түмэн жижиг файл агуулж байвал тэдгээрийн ашиглагдаагүй хэсгүүдийн нийлбэр асар их болно. Жишээлбэл, 2 Кбайт кластертай диск дээр ойролцоогоор 0.5 Кбайт хэмжээтэй 100 жижиг файл бичихэд 150 Кбайт дискийн хэсэг ямар ч ашиггүй үрэгдэх болно. Иймд дискийн зайг үр ашигтай зарцуулья гэвэл кластерийн хэмжээг аль болох багаар зохион байгуулах шаардлагатай. Дискийн кластерийн хэмжээг багасгах **FAT32** файлын системийг ашиглах, дискийг хуваах гэсэн хоёр арга байдаг.

Диск хуваах

Хатуу диск нэг хэсгээс тогтож байвал түүнийг **C:** гэж тэмдэглэх ба хэсгүүд болгон хуваасан тохиолдолд тэдгээрийг **D:, E:** г.м. латин цагаан толгойн үсгүүдээр тэмдэглэдэг. Хатуу дискийг янз бүрийн хэмжээтэй дөрөв хүртэлх хэсэг болгон хувааж болдог. Энэ зорилгоор хэрэглэгддэг DOS болон Windows 9х системд **Fdisk, Format** гэсэн системийн программууд байдаг.

Fdisk программ хатуу дискийг хуваах, хуучин хуваалтыг устгах, **Format** программ дискийг форматлах, файлын системийг тогтооход тус тус зориулагддаг.

Fdisk, Format программыг хэрэглэх үед диск дээр байсан хуучин файлууд арчигддаг учир зайлшгүй хэрэгцээтэй программ болон файлуудын нөөц хувилбарыг хийх шаардлагатай. Дискийг хуваасны дараа хэсэг тус бүрийг формат программаар форматлаж өгдөг. Сонгосон **Windows** системийн хувилбараас хамаарч **FAT16, FAT32** файлын системийг тогтоож өгнө. Харин **Windows 9x** хувилбарын тухайд файлын системийг хэрэглэгч өөрөө сонгон өгч болдог.

FAT32 файлын системийг ашиглах

Хэрэв дискэнд олон программ, файл байгаад тэдгээрийг нөөцлөн хадгалах боломжгүй бол кластерийн хэмжээг хялбархан багасгаж болно. Өөрөөр хэлбэл, **FAT16** файлын системийг FAT32 файлын системд хөрвүүлж болдог. Энэ зорилгоор хэрэглэгддэг **Partition Magic, Extra Strangth Partition** гэсэн программуудыг ашиглаж болно. Эдгээр программыг ажиллуулахдаа **Windows** системийн харгалзах лавлахыг ашиглавал зохино.

Нөөц диск суурилуулах

Нөөц дискийн төхөөрөмж нь зөөвөрлөхөд тохиромжтой, найдвартай, багтаамж ихтэй

байдаг. Ийм дискийг найдвартай газарт хадгалж болохоос гадна ажлаа хийж дуусангуут авч явсан ч болдог. Нөөц диск нь компьютерийн хард дискэн дээр зай хэмнэхийн тулд аудио, видео, график зэрэг их хэмжээний зай эзэлдэг мэдээллийг хадгалахад нэн тохиромжтой. Мөн электрон шуудангаар явуулж болохооргүй хэмжээний мэдээллийг зөөвөрлөхөд ашиглана. Одоо үед Iomega компанийн 2 Гбайт багтаамжтай J -диск , 100-200 Мбайт багтаамжтай **Zip** дискийг өргөн хэрэглэж байна. Эдгээрээс гадна 120 Мбайт багтаамжтай **Super Disk** буюу LS -120 диск төхөөрөмж, **Castlewood** компанийн 2,2 Гбайт багтаамжтай Orb- диск төхөөрөмжийг ашиглах болжээ. Orb диск төхөөрөмжийн онцлог нь үнэ хямдтай диск ашигладаг явдал юм. Ийм диск төхөөрөмж сонгохдоо **USB**(универсал цуваа түгээгүүр)-д юмуу эсвэл компьютерийн зэрэгцээ портонд холбогддог төхөөрөмж сонгох хэрэгтэй. Эдгээр нь суурилуулахад хялбар, зөөвөрлөхөд тохиромжтой байдаг.**IDE, SCSI** интерфейстэй диск төхөөрөмжийг холбоход түвөгтэй боловч, хэрэглэхэд тохиромжтой, хурдан байдаг.

SCSI-ИНТЕРФЕЙСТЭЙ ДИСК ТӨХӨӨРӨМЖИЙГ СУУРИЛУУЛАХ Нэгдүгээр алхам.

Компьютер тань **SCSI**-үүр, эсвэл **SCSI**-адаптер байхгүй тохиолдолд **SCSI**-адаптер суурилуулах хэрэгтэй . Сүүлийн үеийн ихэнх **SCSI**-адаптерууд Plug & Play технологиор хийгдсэн байдаг. **SCSI**-адаптерыг суулгахын тулд уг төхөөрөмжтэй цуг ирдэг хэрэглэгчийн зааврыг дагах хэрэгтэй.

Хоёрдугаар алхам. ID-дугаар тохируулах. SCSI төхөөрөмж бүр ID дугаартай байдаг бөгөөд тухайн диск төхөөрөмжийн jump-ын тусламжтайгаар тодорхойлдог. Суурилуулж байгаа диск төхөөрөмж компьютерийн тань хувьд цорын ганц SCSI-төхөөрөмж болж байгаа тохиолдолд ID-дугаарыг өөрчлөхгүй, хэвээр нь үлдээж болно. Эсрэг тохиолдолд SCSI төхөөрөмжөө шалгах хэрэгтэй бөгөөд SCSI төхөөрөмжүүд голдуу дөрөв эсвэл тав гэсэн ID дугаартай байдгийг анхаарвал зохино.

IDE интерфэйстэй диск төхөөрөмж суурилуулах

Нэгдүгээрт

Компьютерээ унтрааж, процессорынхоо тагийг авна. Системийн плат дээр Primary, Secondary гэсэн хоёр IDE суваг байгааг ажиглах хэрэгтэй. Нэг IDE сувагт нь <u>хатуу диск</u>, нөгөөд нь <u>CD-ROM</u> төхөөрөмж холбогдсон байдаг. Зарим тохиолдолд хатуу диск, CD-ROM төхөөрөмж хоёр нэг кабелиар системийн платын нэг IDE сувагт холбогдож болдог. Ийм тохиолдолд шинэ төхөөрөмжөө түүнтэй цуг ирдэг кабелиар хоёр дахь IDE сувагт холбох хэрэгтэй.

Хоёрдугаарт

Шинэ диск төхөөрөмж тань нэг IDE сувагт хоёр дахь төхөөрөмж болон холбогдож байвал стандарт тохиргоо нь Primary буюу Master байдаг тул vvнийг Slave горимд оруулахын тулд jumper-аар өөрчлөнө. Харин диск төхөөрөмж тань ганцаараа IDE кабельд холбогдсон тохиолдолд jumper-г "Master"горимд нь байрлуулна. Хатуу диск холбосон кабельд нэмэлт төхөөрөмж холбох болвол хатуу дискийн jumper-ийг "Master", нэмэлт төхөөрөмжийнхийг "Slave"горимд тохируулах хэрэгтэй.

SCSI, IDE ТӨРЛИЙН ДИСК ТӨХӨӨРӨМЖ

Кабелиа холбож, диск төхөөрөмжөө суурилуулна. Vvний тулд процессор дээр диск төхөөрөмж байрлуулах сул зай сонгож авах хэрэгтэй. Шинэ <u>SCSI</u> адаптер суулгаж байгаа тохиолдолд тvvнийг баруун талын (өгөгдлийн) SCSI кабелийн vvрэнд холбоно. Кабелийн сул vзvvрийг диск төхөөрөмжид холбоно. Өгөгдлийн кабелийн эхний контакт нь (ихэвчлэн улаан шугамаар тэмдэглэгдсэн байдаг) диск төхөөрөмжийн нэг дэх контактад холбогдоно. Дараа нь тэжээлийн кабелийг залгаж, төхөөрөмжөө процессорын сул зайд суулгаж өгнө.

Нөөц диск сонгох

Тэгвэл мэдээллийн нөөц хувь хийж хадгалахад илvv тохиромжтой, багтаамж, хурд ихтэй диск төхөөрөмжийн манлайд Iomega компанийн **Zip (100M6), Digital Research, Hi-Val, Imation, Winstation** компаниудын LS-120 технологи ашиглан vйлдвэрлэдэг **SuperDisk** (120M6) диск төхөөрөмж зайлшгvй орно.

Харин энэ хоёр диск төхөөрөмжийн аль нь илvv вэ? гэсэн асуулт гарах нь мэдээж. Хvн бvр өөр өөрийн сайн муу талтай байдгийн адил энэ хоёр диск төхөөрөмжийн хувьд ч бас сул болон давуу тал бий.**Zip** диск төхөөрөмжийн хувьд маш өргөн тархсан, бараг бvx компьютер vйлдвэрлэгчид ашигладаг. Статистик мэдээнээс vзэхэд 99 доллараас 149 долларын vнэ бvxий 15 сая гаруй **Zip** диск төхөөрөмж ашиглагдаж байна.**LS-120** диск төхөөрөмж бол дээрхтэй харьцуулахад хурд, багтаамж ихтэй, өөрийн 120Мбайт багтаамжтай дискнээс гадна 1.44 Мбайт багтаамжтай диск унших чадвартай. Уг диск төхөөрөмжийг **Compaq, Gateway, Hewlett Packard, IBM, NEC** зэрэг фирмvvд ашиглаж байна.

SCSI- интерфейстэй диск төхөөрөмжийг суурилуулахад SCSI- адаптер шаардагддаг. Энэ нь уг төхөөрөмжийг илvv хурдан ажиллуулах vvpэг гvйцэтгэнэ.

Зэрэгцээ порттой диск төхөөрөмж 300 Кбайт/с орчим хурдтай ажилладаг бол SCSIинтерфейстэй диск төхөөрөмж даруй гурав дахин хурдан ажилладаг ажээ. EIDEинтерфейстэй дотоод LS-120 болон Zip диск төхөөрөмж ашиглавал өгөгдөл дамжуулах хурдыг 1Мб/с хүртэл нэмэгдүүлэх боломжтой. Диск төхөөрөмж сонгон авахад системийн плат чухал үүрэгтэй. Иймээс нэр хүнд бүхий корпорацийн бүтээгдэхүүнийг зөв таньж сонговол зохино. Дараах хүснэгтэд Intel фирмийн системийн платын үзүүлэлтүүдийг толилууллаа.Тааруухан зохиогдсон, тестлэгдээгүй системийн плат худалдаж авснаар хатуу диск болон видеоплат зэргийг худалдан авахаас өөр аргагүй болох явдал цөөнгүй тохиолддог. Иймээс системийн плат сонгохдоо бусад төхөөрөмжүүдтэй зохицон ажиллаж чадах эсэхийг нь анхаарах хэрэгтэй. ASUS, Intel, Super Micro зэрэг туршлагатай үйлдвэрлэгчдийн найдвартай бүтээгдэхүүнийг үнэ хайрлахгүй авбал таны компьютер баталгаатай ажиллах үндэс болохоос гадна тухайн компанийн сайтаас мэдээлэл, тусламж авах боломжтой байдаг.

Системийн плат дээрх микросхемийн багц нь төв процессор, шуурхай санах ой, кэш санах ой, график плат, хатуу диск болон бусад гадаад төхөөрөмжvvдийг холбосон тvгээгvvрийн хооронд явагдах өгөгдлийн урсгалыг хянах vvрэг гvйцэтгэнэ.

Мэдээллийг дараах хаягаар хандан авч болно.

- EIDE интерфейстэй SuperDisk LS - 120 (дотоод) диск төхөөрөмж

http://www.hival.com

- EIDE интерфейстэй LS - 120

http://www.dr-tech.com

- SCSI интерфейстэй LS -120 (дотоод) диск төхөөрөмж

http://www.winstation.com

- Зэрэгцээ порттой LS -120 диск төхөөрөмж

http://www.superdisk.com

- Zip диск төхөөрөмж

http://www.iomega.com

Шинээр хатуу диск суурилуулах

Шинээр хатуу диск суурилуулах нь тийм ч хэцvv ажил биш боловч өөртөө итгэхгvй бол техникийн vйлчилгээний албанд хандах хэрэгтэй. Хэрэв та өөртөө итгэлтэй байгаа бол худалдаж авсан дискнийхээ дагалдаж ирсэн заавар зөвлөгөөг дагах нь чухал. **Seagate** фирмийн диск төхөөрөмж суурилуулахад хамгийн хялбар, ойлгомжтой байдаг. Tvvний корпус дээр энгийн ойлгомжтой заавар байхаас гадна тухайн компьютерт анализ хийж, дараа нь тvvний тухай мэдээлдэг, юу хийх хэрэгтэйг алхам алхмаар зааварласан программ

дагалдаж ирдэг. Уг диск нь 1994 оноос хойш vйлдвэрлэгдсэн EIDE интерфейстэй компьютерvvдийн алинд нь ч тохирно.Харин SCSI интерфейстэй диск төхөөрөмж SCSI контроллер шаарддаг бөгөөд голдуу файл серверт зориулагдсан байдаг.Хэрэв компьютер тань vйлдвэрлэгдсэнээсээ хойш гурваас дээш жил болж байгаа бол тvvний BIOS 8.4 Гбайтаас дээш багтаамжтай дискийг хvлээн зөвшөөрөхгvй байх бvрэн vндэстэй.EIDE интерфейстэй UltraDMA/66, UltraATA/66 дискнvvд өгөгдлийг 66 Мбит/сек хурдаар дамжуулдаг. Cvvлийн гурван жилийн дотор vйлдвэрлэгдсэн компьютерvvд UltraDMA/33 стандарттай байдаг бөгөөд тvvнийг UltraDMA/66-аар солихын тулд Promise Technology (www.promise.com) фирмийн Ultra66 өргөтгөлийн платыг давхар суулгах хэрэгтэй.

Доргилтоос болж vvсэх гэмтлээс хатуу дискийг хамгаалах

Компьютерийн хатуу диск дээрх мэдээлэл устаж vrvй болох, гэмтэх тохиолдол олон янзын шалтгаантай байж болно. Винчестерийн гэмтлийн талаас илvv хувь нь доргилт, чичиргээ, унагаах зэрэг механик ажиллагаанаас болдог байна.Гаднын механик vйлчилгээнээс хатуу дискэнд vvcч болох гэмтлийн талаар болон ийм vйлчлэлээс хатуу дискийг хамгаалах сvvлийн veийн технологийн талаар танилцуулъя.Компьютерийн дурын эд ангийн нэгэн адил хатуу дискийг бага боловч өндрөөс унагахад гаднаас нь харахад гэмтээгvй мэт боловч дотор талын хэсгvvд нь амархан гэмтдэг.Үйлдвэрээс технологийн нарийн шалгалтаар шалгагдаж гардаг учир гэмтэлтэй диск гардаггvй байна.Компьютерийн корпуст суурилагдсан диск дан дискийг бодвол доргилтод харьцангуй бага өртдөг. Энэ нь компьютерийн корпус доргилтын зарим хэсгийг өөртөө шингээдэгтэй холбоотой.Зураг 1-д механик vйлчлэлийн нөлөөгөөр хатуу дискэнд vйлчлэх хvчний хэмжээг хугацаанд харьцуулсан графикийг vзvvлсэн байна.

Босоо тэнхлэгийн хувьд чөлөөт уналтын хурдатгалд харьцуулсан хvчний хэмжээ, хэвтээ тэнхлэгийн хувьд vйлчилсэн хугацааг авчээ.Графикаас vзэхэд богино хугацаанд их хvчээр vйлчилсэн тохиолдолд диск гэмтэх эрсдэл хамгийн их байдаг байна. Yvний улмаас дискийн уншигч толгой гэмтэх, холхивчинд сул гvйлт бий болох, дискэнд хөдөлгөөн vvcэх зэрэг гэмтлvvд vvcдэг.

Цохилтын vp дvнд vvcэх гэмтлээс хамгийн тvгээмэл нь дискийн уншигч толгой гэмтэх явдал юм. Цохилтын хvч хэвтээ тэнхлэгт перпендикуляр буюу тодорхой өнцөг vvcгэн vйлчлэх veд yншигч толгой дискийн гадаргуугаас огцом салж, буцаж унахдаа дискийн гадаргууг зурна. Ингэснээр дискийн гадаргуу дээр маш олон тооны жижиг талстууд бий болж тархдаг. Дискийн орчимд vvcэх соронзон орны нөлөө, талстуудын хэмжээ зэргээс шалтгаалан талстууд дискийн гадаргуу дээр vлддэг байна. Уншигч толгой доргилтын улмаас физик гэмтэл авах бvрэн боломжтой. Yvнээс улбаалан уншигч толгойн соронзон

шинж чанар мэдэгдэх үйц муудсанаас эвдрэлтэй кластерууд үүсдэг байна.

Иймээс диск vйлдвэрлэдэг компаниуд цохилт, доргилтын улмаас дискэнд vvсэх гэмтлийг багасгах зорилгоор олон янзын технологи ашигладаг. **1. SPS технологи**

Quantum фирмийн **SPS** (Shock Protection System) технологи нь 1998 оны эхний хагаст гарсан бөгөөд **Fireball TM EL** төрлийн винчестерт хэрэглэгддэг. Дискийн гадаргуугаас уншигч толгой хүртэлх зайг багасгаснаар цохилтын үед үүссэн үндсэн энерги диск төхөөрөмжийн бусад эд ангиудад шингэдэг байна. Ингэснээр дискийн гадаргууд орох өөрчлөлт бараг үгүй болдог. **2. SPS II технологи**

SPS технологи нь компьютер ажиллаагvй veд дискийг доргилтоос хамгаалах зориулалттай бол **SPS II** технологи нь компьютер ажиллаж байх veд хатуу дискийг доргилтоос vvcэх гэмтлээс хамгаалах технологи юм.

Уг технологийн онцлог нь системийн блокт доргилт vvсcэн veд дискэнд бичигдэж байсан мэдээлэл тvp санах ойд бичигдэж, доргилтын хугацаа дууссаны дараа дискэнд бичигддэг байна. Зураг 4-т **SPS II** технологи ашиглаагvй, зураг 5-д тухайн технологи ашигласан veийн дискэнд доргилт vvcэхэд явагдах процессыг тус тус vзvvлжээ.

SPS II технологийг Quantum фирмийн Fireball Ict, Fireball Ict10k, AtlasV загварын дискvvдэд ашигласан байдаг. 3. Seagate компанийн GFP (G-force protection) технологи Уншигч толгойн хэмжээ, жинг багасгаж, диск болон тvvнийг бэхлэгч биесийн хоорондох зайг ихэсгэснээр цохилтын veд тэдгээрт vvcч болох кинетик энергийн хэмжээг мэдэгдэхvйцээр багасгадаг. Тус компанийн мэргэжилтнvvд доргилтын veд холхивчинд vvcэх гэмтлийг багасгах зорилгоор диск бага зэрэг байрнаасаа хөдөлсөн тохиолдолд тvvний уншигч толгой мөн дагаж байрлалаа өөрчилж байхаар тооцоолсон байна. Уг технологи нь Seagate Barracuda TM 18LP/36/50, Cheetah TM 18LP/36 диск төхөөрөмжvvдэд ашиглагдаж байна. Дээрх компаниудаас гадна Maxtor, Fujitsu, Samsung, Western Digital зэрэг компаниуд ч мөн дискийг доргилтоос хамгаалах талаар өөрсдийн технологийг ашигладаг байна.

Уян дискийн төхөөрөмжийг компьютерт хэрхэн таниулах

Vvний тулд та компьютераа анх асах veд нь **CTRL+ALT+DEL** товчийн тусламжтайгаар setup-руу орох хэрэгтэй. Vvний дараа гарч ирэх хvснэгтээс доорх дарааллаар уян диск төхөөрөмжийг өөрийн компьютерт суурилуулна.

1. Setup-ийн мэдээлэл бүхий хүснэгтээс STANDART CMOS SETUP гэсэн мөрийг сонгож ENTER товч дарна.

2. Гарсан хvснэгтээс Floppy drive A: Not installed гэсэн байвал Page Up эсвэл Page Down

товчлуурын тусламжтайгаар 1.44 MB 3.5" болгоно.

3. ESC товчлуурыг дарж уг цонхоо хаана.

4. F10 товчлуурыг дарахад WRITE TO CMOS AND EXIT? (SAVE CURRENT SETTINGS AND EXIT?) Y or N гэсэн асуултанд Y буюу Yes гэж хариулна. Ингэснээр таны компьютер уян дисктэй харьцах боломжтой болох юм.

Дискийг ажилд бэлдэх (Форматлах) Vvний тулд таны компьютер MS_DOS, WINDOWS 9x; 2000 ME; NT системийн аль нэг дээр ажилладаг байх хэрэгтэй. Учир нь vvнийг систем программын командын тусламжтайгаар гvйцэтгэдэг байна. Харин дискэнд мэдээллийг бичихийн тулд хамгаалалтыг авах хэрэгтэй.

MS_DOS системээс дискийг форматлахдаа: Дэлгэцийн доод буланд C:\> format a: Системтэй форматлах бол C:\> format a: /s гэсэн командыг гараас бичиж өгнө.

Vvний дараа дэлгэц дээр доорх бичиг гарахад All data in your diskette will be lost!!! Do you wish to continue ? Y or N Гэсэн асуултад Y буюу Yes гэж хариулна.

Бусад асуултанд Enter товч дарснаар таны диск ажилд бэлэн болно.

Одоо бусад системийн хувьд авч vзье.

Дэлгэцэн дээрх My Computer-г нээж Floppy A гэсэн тэмдэг дээр хулганыхаа баруун талын товчийг даран гарч ирэх цонхноос Format-г дарна.

Vvний дараа гарч ирэх цонхноос дискээ ямар аргаар форматлахаа командуудыг тэмдэглэх замаар сонгож start товчлуур дээр дарна.

Харин энэ veд дискнийхээ хамгаалалтыг авсан байх хэрэгтэй.

Дискнээс хуулах

MS_DOS-ын горимд дискнээс хуулахдаа дэлгэцийн доод буланд A:/> сору [file-ийн нэр]

[хуулагдах диск буюу директор] гэсэн форматтай командыг өгнө.

Дискэнд хуулахдаа мөн C:/> copy [file-ийн нэр] [хуулагдах диск буюу директор]: гэсэн форматтай командыг өгнө.

Windows-ын төрлийн системийн хувьд Windows explorer дотор А диск дээр байгаа файлуудаа гаргаж хуулах файлаа тэмдэглээд хулганыхаа зvvн товчлуур дээр дарж сору командыг дарна.

Ингэсний дараа дахин хуулах диск буюу директорийнхоо нэр дээр очиж мөн хулганыхаа зvvн товчлуур дээр дарж гарсан цонхноос paste командыг дарна.

Харин уян диск руу хуулах бол дээрхийн эсрэгээр командын дарааллыг алдагдуулалгvй гvйцэтгэнэ.

Монитор

Дэлгэц суурилуулахийн тулд

Монитор буюу дэлгэцийг компьютерт суурилуулахын тулд видео адаптер байх шаардлагатай.

Эхлээд видео адаптераа процессортоо суулгаад дэлгэцний арын хэсгээс гарч буй холбогч кабелыг видео адаптерний портонд, тэжээлийн залгуурыг тогонд тус тус залгана. Үvний дараа компьютерээ асааж дэлгэцтэй хамт дагалдаж ирсэн инсталл буюу драйвер дискийн тусламжтайгаар дэлгэцийг таниулна. Драйвер диск дагалдаж ирээгvй бол дэлгэцийг vйлдвэрлэсэн газрынх нь вэб хуудаснаас татаж авч болно.

Дэлгэцнийхээ төрлийг хэрхэн мэдэх вэ?

Windows системээс Start->Settings->Control Panel-г сонгоод System цонхыг сонгоод хоёр дарахад System Properties цонх нээгдэнэ. Энэ цонхны Device Manager хэсгийг сонгоод Monitor талбар дээр хоёр дарахад таны дэлгэцийн төрөл гарч ирнэ.

Дэлгэц өнгө болон хэмжээг хэрхэн өөрчлөх вэ?

Windows системээс Start->Settings->Control Panel-г сонгоод Display цонхыг 2 дарж орно. Ерөнхий цэснээс Settings-г сонгоод *Colors* гэдгийн доор өнгөний хэмжээ, *Screen area* -гаас дэлгэц дvрслэгдэх хэмжээг сонгох замаар өөрчилж болно. Дэлгэцний гэрэл нь анивчаад байгаа атлаа ажиллахгүй бол яах вэ?

Энэ тохиолдолд компьютерээ унтраасны дараа дэлгэцээ салгаж аваад өөр зvгээр ажиллаж байгаа компьютерт холбоод vз. Ингэхэд ажиллахгvй байвал дэлгэц тань гэмтэлтэй байна гэсэн vг бөгөөд засуулах эсвэл солих шаардлага гарч ирнэ. Харин зvгээр ажиллаж байвал таны видео адаптер гэмтэлтэй эсвэл тохирохгvй байна гэсэн vг.

Иймд видео адаптераа өөр компьютерт суулгаад ажиллаж байвал таны видео адаптер, дэлгэц хоёр хоорондоо зохицохгvй байна гэсэн vг.

Гэхдээ зарим тохиолдолд хятадын олон залгуурт нилээд олон зvйл зэрэг залгасан нөхцөлд тог хангалттай хүрэлцээгүйн улмаас дэлгэцийн гэрэл нь анивчаад ажилладаггүй юм.

Дэлгэцийн гэрэл нь асахгүй мөн ажиллахгүй байвал яах вэ?

Энэ тохиолдолд дэлгэцнийхээ тэжээлийн залгуурыг солиод vз, болохгvй бол таны дэлгэц гэмтэлтэй байгаа учир засуулах эсвэл солих шаардлагатай.

Дэлгэц маань өнгөт атлаа хар цагаан өнгөөр гараад байна, үүнийг хэрхэн засах вэ?

Windows системээс Start->Settings->Control Panel -г сонгоод Display цонхыг 2 дарж орно. Ерөнхий цэснээс Settings -г сонгоод *Colors* гэсний доор хар цагаанаар тохируулагдсан байвал өөрчлөх шаардлагатай.

Дэлгэц тань олон өнгө ялгаруулж чадахгүй байвал тохиргоог яаж хийх вэ?

Start->Settings->Control Panel -г сонгоод Display цонхыг 2 дарж орно. Үvний дараа ерөнхий цэснээс Settings -г сонгоод *Colors* гэсний доорх өнгөний хэмжээг өөрчил.

Дэлгэц тань өнгөт боловч тоглоом тоглох гэхээр график дурслэл муу байвал яах вэ? Ийм тохиолдолд тоглоом тоглоход хэрэглэгддэг **DirecX** программийн илуу сайн хувилбарыг олж суулгана уу.

Дэлгэцнээс нудээ яаж хамгаалах вэ?

Дэлгэц гэдэг маань телевизортой адилхан зарчмаар ажилладаг учир телевизор vзэхэд ажиглагддаг нvд чилэх, аргах, хараа муудах зэрэг бэрхшээлүүд бvгд бий. Иймээс эхний ээлжинд дэлгэцний хаалт болох шилэн фильтер авч тавина уу. Мөн нvдээ ve ve амрааж ондоо зvг pvv хараагаа хандуулж бай.

Дэлгэцийг арчиж цэвэрлэхэд юуг анхаарах хэрэгтэй вэ?

Дэлгэц нь телевизортой адилхан зарчмаар ажилладаг учир телевизор шиг өндрийн тэжээлийн хэсэгтэй их хэмжээнмй хүчдэл хуримтлуулдаг учир хамаагvй арчиж цэвэрлэх юм бол дэлгэцэндээ гэмтэл учруулахаас гадна өөртөө гэмтэл учруулж болно. Иймээс дэлгэцээ унтраагаад нэлээд хугацаа өнгөрсний дараа бага зэрэг чийгтэй алчуураар эсвэл бvp их хиртэж загалтаагvй бол хуурай алчуураар арчиж бай. Хэрэв чийгтэй алчуурааар арчсан бол арчингуут яаралтай компьютерээ асаах хэрэггvй.

Hub ашиглалгvйгээр дотоод сvлжээнд 2 компьютерийг хооронд яаж холбох вэ?

Ethernet сvлжээнд 2 компьютерийг дотоод сvлжээний Hub төхөөрөмж ашиглалгvйгээр зөвхөн кабелиар хооронд нь холбож болдог. Мэдээж 2 компьютерт хоёуланд нь дотоод сvлжээний карт суулгасан байх шаардлагатай. UTP CAT5 төрлийн кабелын 2 v3vvpт RJ45 коннектороо холбохын тулд эхлээд кабелийн утаснуудыг дугаарлах шаардлагатай.

UTP кабель нь дотроо 8 өнгийн утаснаас бvрддэг. RJ45 коннекторт кабелын 2 vзvvрийг хавчихдаа гаднах хаймран бvрээсийг 1.5 см хэртэй хуулж, дотроос нь гарах утаснуудыг нэг нэгээр нь салгаж тэнийлгэнэ. Ингээд коннекторыг дараах байдлаар барьж, утаснуудыг дарааллуулан байрлуулж тусгай зориулалтын бахиар хавчина. Коннекторын нэг тал цулгай бөгөөд нөгөө тал нь тvгжигч сэртгэр байдаг. Энэ сэртгэр нь кабелийг дотоод сvлжээний карт болон Hub төхөөрөмжинд залгахад тvгжээс болж өгдөг vvрэгтэй. Энэ тvгжээс сэртгэрийг дээш нь харуулж, кабель орох хэсгийг өөр лvvгээ харсан байдлаар харин толгойг нь нөгөө тийшээ харсан байдлаар барина. Ингээд зvvн гараас эхлэн кабелийн утаснуудыг дугаарлах ёстой. Нэг талын vзvvрийг хавчихдаа утаснуудыг дараах байдлаар байрлуулна:

Зуун гараас

- 1 Шар алаг
- 2 Шар
- 3 Ногоон алаг
- 4 Цэнхэр
- 5 Цэнхэр алаг
- 6 Ногоон
- 7 Хүрэн алаг
- 8 Хүрэн

Одоо нөгөө талын vзvvрийн утасны дарааллыг тайлбарлъя: Мөн коннекторын сэртгэрийг дээш нь харуулж бариад зvvн гараас дараах байдлаар байрлуулна. 1 Ногоон алаг 2 Ногоон 3 Шар алаг 4 Цэнхэр 5 Цэнхэр 5 Цэнхэр алаг 6 Шар 7 Хvрэн алаг 8 Хvрэн Ингээд хавчсаныхаа дараа харахад кабелын нэг талын vзvvрийн 1, 2 -р утас нөгөө

инг ээд хавчсаныхаа дараа харахад каослын нэг талын үзүүрийн 1, 2 -р угас нөгөө үзүүрийн 3, 6 -р утастай холбогдоод бусад нь 4 нь 4 -тэй, 5 нь 5 -тай, 7 нь 7 -той, 8 нь 8 тай холбогдож байгаа.

Та үүнийг мэдэх үү?

Хадгалагдсан Web хаягуудыг устгах /Clear History/ Хадгалагдсан Web хаягуудыг устгахдаа Internet Explorer-ийн Tools цэсний Internet Options -oop opood "Clear History" товчлуурыг дарна. Заримдаа энэ арга vp дvнд хvpгэдэггvй тохиолдол гардаг. Тэгвэл доорх аргаар туршаад vзээрэй. Компьютерийн системийг DOS-ын горимд ачаална. Yvний тулд:

Start> DOS Shutdown> restart in MS DOS Mode гэсэн дарааллаар Windows-ийг Restart хийнэ.

DOS-ийн командын мөрөнд cd \windows гэж бичээд enter дарна. Дараагийн мөрөнд deltree history гэж бичээд enter дарна. Windows-оо дахин ажиллуулаарай Хадгалагдсан хаягууд одоо устгагдсан байх болно.

A:Windows98 суулгасны дараа Fax дамжихгvй байна.

X: Хэрэв та өөрийн компьютерийн <u>Windows95 vйлдлийн систем</u>ийг <u>Windows98SE</u> болгон шинэчилсэн бол таны <u>Fax</u> -ын программ ажиллахгvйд хvрдэг.

Учир нь Microsoft Fax-ийн <u>fax</u> дамжуулах болон хvлээн авах гол файл хасагдчихдаг байна. Иймд та доорх өөрчлөлтийг хийх шаардлагатай.

Mapi32.dll гэсэн нэртэй файлийг олоод нэрийг нь Mapi32.old болгож өөрчилнө. Дараа нь Mapi32x.dll гэсэн нэртэй файлийг олоод мөн нэрийг нь Mapi32.dll болгож өөрчилнө.

MS Excel-ийн нүдэнд мөр оруулах

MS Excel дээр ажиллаж байгаа veд xvcнэгтийн нэг нvдэнд олон мөрөөр бичих хоёр арга байдаг.

1. Тухайн нүдэндээ курсороо байрлуулаад ALT+ENTER товчуудыг зэрэг дарна.

Тухайн нүдэн дээрээ курсороо байрлуулна. Дараа нь Format цэсний Cells -ийг сонгоод
 Alignment гэсэн хуудсанд орно. Wrap text гэсэн мөрийн өмнө тэмдэглэгээ хийнэ.
 Ингэснээр мөн л нүдний зайг өргөсгөх нариисгах боложтой болдог байна

> Windows Explorer-ийг хэрэгцээт Folder-ийг шууд нээхээр ачаалах

Vvний тулд Start цэсний Run мөрөнд

START гээд "FOLDER-ийн нэр"

гэсэн форматтайгаар командаа бичээд ОК товч дарна.

Жишээ нь: С дискний My Documents-ийг нээх бол START C:MY DOCUMENTS гэсэн команд өгөхөд Windows Explorer дээр My Documents нээгдэнэ.

Сулжээн дэх дискэнд хандалт уусгэх

Сvлжээний хэрэглэгчдэд өдөр тутам хэн нэгний компьютерээс **file** хуулж авах болон дамжуулах шаардлага гардаг. Тэгвэл байнга ордог харилцагчийнхаа share хийгдсэн директор болон дискийг өөрийн компьютер дээрээ сүлжээний диск байдлаар тохируулах бололцоо байдаг.vvний vp дvнд сvлжээний диск нь таны дотоод хатуу дисктэй зэрэгцэн харагдах болно. Хэрэв та үүнийг хийхийг хvсвэл **Network Neighborhood** -pyy орсны дараа сонгосон хэрэглэгч pvv орон **share** хийгдсэн директор болон дискэн дээр хулганыхаа баруун товчийг дарна. Vvний дараа **Map Network Drive** гэж дарснаар сvлжээний диск бэлэн болно. Хэрэв "Reconnect at logon" гэсэн сонголтыг ашиглавал та компьютерээ асаахад сүлжээний дискийг дахин ачаалж чаддаг.

Microsoft Word-ын гэмтсэн файлыг хэрхэн сэргээх вэ?

Microsoft Word-ын гэмсэн файлаас текстийг дахин сэргээхийн тулд Recover Text from Any File option сонголтыг ашиглана.

Харин текстээс бусад хийгдсэн формат, график өөрчлөлт, зургын объект, хөл толгойн текст, ишлэлүүд зэргийг урьд байсан байдлаар нь сэргээх боломжгүй ба харин эдгээрийг жирийн текст хэлбэрээр сэргээх боломжтой байдаг. Хэрэв уг сонголт таны Word -ын командууд дотор байхгүй бол үүнийг суулгах шаардлагатай.

Microsoft Word -ын гэмтсэн файлаас текстыг сэргээхдээ:

1. File цэсний Open руу орно.

2. Files of type хэсгээс Word - 97,2000,2002 -ийн хувьд "List Files of Type :", Word 98-ын хувьд "Show :", Word 2001 болон Х -ын хувьд "Recover Text from Any File"-ыг сонгоно.

3. Сэргээх документаа нэг удаа дарж тэмдэглээд **Ореп**-ийг дарна.

Recover Text Converter-г ашиглан файлыг хэрхэн сэргээх вэ?

Уг сонголтыг ашиглан Microsoft word-ын биш документуудын хувьд гэмтсэн файлын текстийг сэргээж болно. Ингэхдээ:

1. Microsoft Word 97, 2000, 2002-ын хувьд **Tools - Options**, Microsoft Word 98-ын хувьд **Tools - Preferences**, Microsoft Word 2001-ын хувьд **Edit - Preference**s, Microsoft Word Х-ын хувьд **Word -Preferences-**ийг сонгоно.

2. General-ыг дараад гарч ирэх харилцах цонхноос Confirm conversion at Open-ийг сонгон OK ийг дарж гараад , File цэсний Open ыг нээнэ.

3. Files of type хэсгээс Word - 97,2000,2002 -ийн хувьд "List Files of Type:", Word 98-ын хувьд "Show:", Word 2001 болон Х -ын хувьд "Recover Text from Any File"-ыг сонгоно.

4. Сэргээх файлаа сонгоод нэг удаа дарж тэмдэглэн Open-ыг нээнэ.

5. Convert File гэсэн харилцах цонх гарч ирэхэд Recover Text from Any File- ийг сонгож ОК-ыг дарж дуусгана.

Microsoft Word-ын гэмтсэн файлыг хэрхэн сэргээх вэ?

Microsoft Word-ын гэмсэн файлаас текстийг дахин сэргээхийн тулд Recover Text from Any File option сонголтыг ашиглана.

Харин текстээс бусад хийгдсэн формат, график өөрчлөлт, зургын объект, хөл толгойн текст, ишлэлүүд зэргийг урьд байсан байдлаар нь сэргээх боломжгүй ба харин эдгээрийг жирийн текст хэлбэрээр сэргээх боломжтой байдаг. Хэрэв уг сонголт таны Word -ын командууд дотор байхгүй бол үүнийг суулгах шаардлагатай.

Microsoft Word -ын гэмтсэн файлаас текстыг сэргээхдээ:

1. File цэсний Open руу орно.

2. Files of type хэсгээс Word - 97,2000,2002 -ийн хувьд "List Files of Type :", Word 98-ын хувьд "Show :", Word 2001 болон Х -ын хувьд "Recover Text from Any File"-ыг сонгоно.

3. Сэргээх документаа нэг удаа дарж тэмдэглээд Open-ийг дарна.

Recover Text Converter-г ашиглан файлыг хэрхэн сэргээх вэ?

Уг сонголтыг ашиглан Microsoft word-ын биш документуудын хувьд гэмтсэн файлын текстийг сэргээж болно. Ингэхдээ:

1. Microsoft Word 97, 2000, 2002-ын хувьд **Tools - Options**, Microsoft Word 98-ын хувьд **Tools - Preferences**, Microsoft Word 2001-ын хувьд **Edit - Preference**s, Microsoft Word Х-ын хувьд **Word -Preferences**- ийг сонгоно.

2. General-ыг дараад гарч ирэх харилцах цонхноос Confirm conversion at Open-ийг сонгон OK ийг дарж гараад , File цэсний Open ыг нээнэ.

3. Files of type хэсгээс Word - 97,2000,2002 -ийн хувьд "List Files of Type:", Word 98-ын хувьд "Show:", Word 2001 болон Х -ын хувьд "Recover Text from Any File"-ыг сонгоно.

4. Сэргээх файлаа сонгоод нэг удаа дарж тэмдэглэн Open-ыг нээнэ.

5. Convert File гэсэн харилцах цонх гарч ирэхэд Recover Text from Any File- ийг сонгож ОК-ыг дарж дуусгана.

Хэд хэдэн модем ашиглан сүлжээний холболт хэрхэн хийх вэ?

Уг холболтыг хийхийн тулд дараах vйлдлvvдийг хийнэ.

1. Нэг модем ашиглан Dial-Up Networking холболт хийнэ.

2. Ингэхдээ Dial-Up Networking - Make new connection рүү орж шинэ холболт vvcгэн File цэсний Properties рүү орно.

3. Multilink tab-aac Use additional devices-ыг сонгон Add-ыг дарна.

4. Холболтонд шаардагдах төхөөрөмжийг / модемоо/ сонгон ОК --ийг дарна.

5. Компьютерт суугдсан бүх модемуудаа нэмж оруулах хүртлээ 3.4-р алхмуудыг давтана.

Санамж:

" multilink connection хийхийн тулд таны компьютерт хоёроос доошгүй модем суулгагдсан байх шаардлагаас гадна, модем бүр нэг нэг утасны шугамтай холбогдсон байх ёстой бөгөөд, танд интернэтийн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс multilink connection болон PPP / Point to point protocol/-ийг ашиглах боломжоор хангасан байх ёстой.

" Эхний модемаар амжилттай холбогдсон хэдий ч хоёрдогч модемоор холбогдоход холболт салаад болохгүй байвал танд интернэтийн үйлчилгээ үзүүлэгч ийм төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжоор хангаагүй байна гэсэн үг юм.

" Multilink нь Dial-Up Networking холболтын нэг хэсэг бөгөөд та бусад төрлийн холболтын программ ашиглаж үед энэ холболтыг хийх боломжгүй байдаг.

" Multilink холболт нь ISDN модемд зориулагдсан байдаг боловч өөр өөр хурдтай, хоёр болон түүнэээс дээш анолог модемд ашиглах боломжтой байдаг. Гэвч анолог модем ашиглах нь сериал портын алдаа өгөх, холболтын чанарыг бууруулах зэрэг сул талтай байдаг:

Сулжээнд байгаа бусад компьютеруудыг унтраах

Хэрэв таны компьютерт **Windows NT** суугдсан бол shutcmd.exe гэдэг жижигхэн **utility** программын тусламжтайгаар энэ vйлдлийг гvйцэтгэж чадна.

Жишээ нь: Сvлжээнд байгаа Client-1 гэсэн компьютерийг унтраая. Vvний тулд Start цэсний Run мөрөнд

SHUTCMD \\CLIENT-1 /Y

командыг бичээд ОК товч дарна.

Хэрэв уг машины **IP** хаяг мэдэгдэж байвал / жишээ нь 205.156. 66. 44 / дээрхийн адил командаар уг vйлдлээ гvйцэтгэж болно.

SHUTCMD \\205.156. 66. 44 /Y

командыг бичээд ОК товч дарна.

Microsoft IE дээрх хуудсыг дээшлvvлж, доошлуулах

Microsoft Internet Explorer программ дээр вэб хуудсыг Page Down, Page Up товчлуураас гадна хулганаараа дээшлүүлж, доошлуулах олон арга байдаг боловч хамгийн хялбар нь Spacebar буюу зай авахад хэрэглэдэг товчлуурыг ашиглах явдал юм. Хуудсыг доошлуулахдаа *Spacebar* товчлуурыг, харин буцаад дээшлүүлэхдээ *Shift* товчлуурыг *Spacebar* товчлуурын хамт дарж үйлдлийг гүйцэтгэнэ.

Файлуудыг Recycle bin руу зөөхгvйгээр устгах

Хэрэв та ямарваа нэг файлыг **Recycle bin** руу зөөхгvйгээр устгахыг хvсэж байвал **Delete**-ийг дарах veдээ **Shift** товчыг хамт дарна. / мөн хулганыхаа баруун товчыг ашиглан устгаж ч болно. /

Дээр дурьдсан vйлдлvvд нь таныг тухайн файлыг шууд устгахад туслах бөгөөд та дараах тохиргоог хийснээр та устгахыг хvссэн бvх файлуудаа **Recycle bin** pvv зөөхгvйгээр устгах боломжтой болно.

- Дэлгэцэн дээрх Recycle bin Icon дээр хулганны баруун товчыг дарж Properties ийг сонгоно.
- Global tab -aac Do not move files to the Recycle Bin ыг сонгоно.
- Configure drives independently -гэдгийг сонговол тодорхой нэг драйвераас устгасан файлыг Recycle bin pvv зөөхгvйгээр шууд устгахыг зааж өгөх боломжтой

болно.



On line цагаа хэмнэхийн тулд

Та өөрийн ашигладаг **E-mail**-ийн программд доорх тохиргоог хийснээр зөвхөн **e-mail** илгээх болон хvлээн авах хугацаанд интернэтэд холбогдох бөгөөд дуусмагц таны холболт автоматаар салах болно. Ингэснээр таны **On line** цаг бага боловч хэмнэгдэх болно.

Outlook Express программын хувьд:

-Vндсэн цэсний Tools-ээс Options-руу орно.

-Нээгдэх цонхны **Connection** гэсэн хуудсыг сонгоно.

-Энд байгаа Hang up after sending and receiving гэсэн vгийн өмнөх тэмдэглэгээг

хийгээд зөвшөөрөх товчлууруудыг дарж нээгдсэн цонхнуудыг хаана.



Eudora программ ашигладаг бол:

-Vндсэн цэсний Tools -ээс Options-ийг (1) сонгоно.

Харин дараагийн хийх үйлдэл таны Eudora программын версээс шалтгаалж өөр байх юм.

Eudora 4.3 -ийн хувьд:

-Options цонхны Category гэсэн баганаас Internet Dial up гэсэн хэсгийг нээнэ.

-Уг цонхны зvvн хэсэгт байгаа **Hang up after receiving and sending (2)** гэсэн vгний өмнөх тэмдэглэгээг хийгээд **OK** товчлуур дарна.

Eudora 3.0, 4.0-ийн хувьд:

-Options цонхны Category гэсэн баганаас Advanced Network гэсэн хэсгийг нээнэ. -Мөн, цонхны зvvн хэсэгт байгаа Hang up after receiving and sending (3) гэсэн vгний өмнөх тэмдэглэгээг хийгээд OK товчлуур дарна.



Microsoft Outlook программын хувьд:

-Vндсэн цэсний Tools-ээс Options-руу орно.

-Нээгдэх цонхны Mail Delivery гэсэн хуудсыг сонгоно.

-Энд Hang up when finished sending, receiving or updating гэсэн vгний

өмнөх тэмдэглэгээг хийнэ.

-ОК товчлуурыг дарж цонхыг хаана



Bootable (Start Up) disk бэлтгэх

Start Up Disk -нь Компьютерийн системийг дотроос нь бус уян дискнээс ачаалах зориулалттай системийн шаардлагатай файлуудыг агуулсан диск юм. Ийм дисктэй

байснаар та хатуу дискээ форматлах, системийн алдааг оношлох, засварлах, вирусын эсрэг программаар системээ бүхэлд нь шалгах боломжтой болдог. Системтэй диск ч гэж нэрлэх нь бас бий.

Windows-ийн **Start Up disk**-ийг бэлдэхэд танд нэг ширхэг 1.44 mByte багтаамжтай уян диск хэрэгтэй.

Ямар дарааллаар уг дискээ бэлтгэх вэ?

- Start товчлуурыг дарж Setting-ийн Control Panel-аас (1) Add/Remove Programs (2) гэсэн хэсгийг нээнэ.

- Vvсэх цонхноос Startup Disk гэсэн хvснэгтийг нээж Create Disk (3) товчлуурыг дарна.



- Одоо vvcэх цонхон дээр та Windows-ийн install disk байгаа замыг зааж OK (4), (5)

товчлуураа дарна.

- Insert disk гэсэн цонх гармагц уян дискээ хийж ОК (6) товчийг дарна.
- Диск бэлэн болмогц дахин ОК (7) дарж цонхыг хаана.

ISP-руу илvv тvргэн холбогдох боломж

Хэрвээ та Интернэтийн vйлчилгээ эрхэлдэг газар (ISP) луу холбогдохдоо зарцуулдаг цагаа аль болох багасгая гэвэл эхлээд My Computer -> Dial-up Networking руу ороод өөрийн

ашигладаг холболтын цонхыг (My connection, Internet г.м) нэг дарж сонгоод хулганыхаа баруун товчлуурыг дарж Properties-г сонго. Гарч ирэх цонхноос Server Types-г сонгоод Log on to Network, NetBEUI, IPX/SPX Compatible Protocol-н өмнөх чагтыг арилгах хэрэгтэй. Дараа нь холбогдож чадаж байгаа эсэхээ шалгаарай.

Ихэнх ISP-нvvд уг тохиргоог хэрэглэдэггvй бөгөөд эдгээрийн өмнөх чагтыг авсанаар холбогдож орох хугацаагаа 60 хvртэлх секундээр хэмнэдэг.

Холболтын болон файл татах хурдыг хянахад System Monitor-г ашиглах нь

Компьютерийн хатуу диск, санах ой, дотоод сvлжээний хурд болон vйл ажиллагааг нь хянадаг System Monitor программийн тохиргоонд Dial-up Networking холболтынх мөн байдаг билээ. System Monitor-т Dial-up Networking холболтыг нэмж өгснөөр секундэд хэдэн байт хvлээн авч, дамжуулж байна гэдгээс гадна өгөгдөл дамжих хурдыг харуулдаг графикаар харуулдаг.

Send То командыг ашиглан объектыг илгээх

Ta **SendTo** folder -т ямар нэгэн shortcut-г хуулж болдог. Shortcut нь принтер, факс, сүлжээний диск (network drive) болон Windows -н программууд байж болно. Жишээлбэл тогмтол ордог Word-н файлын shortcut-г Windows системийн үндсэн цонх болох Desktop дээр гаргахын тулд файлаа нэг дарж сонгоод хулганыхаа баруун товчуурыг дарна. Гарч ирэх цонхноос SendTo командыг сонгоод Desktop-г дарна.

Send to folder-ыг нээхийн тулд Start товчыг дарж Run- г сонгоод командын мөрөнд SendTo гэж бичээд Enter дарна.

Файлын нэр, өргөтгөлийн хэмжээ

Windows 98 системд файлын нэр өргөтгөлийн уртууд нь дараах байдлаар байж болдог:
12345678.ABC (MS-DOS горимд файлын нэр 8, өргөтгөл нь 3 тэмдэгтээс бүрддэг.)
12345678.ABCDEF (өргөтгөл хязгааргүй)
123456789012345678901234567890123456789.ABC (урт нэртэй файл)
123456789012345678901234567890123456789.ABCDEF (нэр, өргөтгөл хоёулаа урт байна)
123456789.ABC.DEF (олон тооны өргөтгөлтэй урт нэртэй файл)
This is a valid file name (хоорондоо зайтай урт нэрүүд бас байж болдог)

> Scan disk-ийг ашиглах

Ta **Scan disk**-ийг хатуу болон уян дискэн дэх бага хэмжээний гэмтэл болон системийн алдаануудыг шалгахад болон засварлахад ашиглаж болно. Өөрөөр хэлбэл программ дээрх алдаа болон дискний секторуудын гэмтлийг засна.

Scan disk-ийг ашиглахын тулд доорх дарааллаар ажиллана.

Vvнд:

Start дээр дарж Programms-aac Accessories-ийг сонгож System tools pvv орон Scan disk-ийг ажиллуулна.

Гарсан цонхноос шалгах гэж байгаа диснийхээ нэрийг тэмдэглэнэ.

Type Of Test гэсэн хэсэгт **Thorough** болон **Automatically Fix Errors** гэсний өмнөх тэмдэглэгээг хийнэ.

Дараа нь Start товчлуурыг дарна.

9 Disk defragmenter

Хатуу дискны ажиллах хурдыг нэмэгдvvлэхэд **Disk defragmenter**-ийг хэрэглэнэ. **Disk defragmenter** нь хатуу дискний ашиглагдаагvй зайг шахах ба хадгалагдсан файлуудыг цэгцэлж программыг хурдан ажиллуулдаг.

Үvнийг ажиллуулахдаа:

Start дээр дарж Programms-ын Accessories-оос System tools-pvv орж Disk defragmenter-г сонгоно.

Select Disk Drive цонхноос шаардлагатай дискнийхээ нэрийг зааж Ок, Start товчлууруудыг дарснаар уг программ ажииллаж эхэлнэ.

• Санамж: Дээрх 2 программ нь нэлээд хугацаа шаардагддаг тул та vvнийг завтай цагаа тааруулж хийгээрэй.

FAT системийг FAT32 болгож хувиргах

Компьютерийн хатуу дискэнд хандах хурдыг сайжруулах, багтаамжийг дээшлүүлэх зорилгоор FAT, FAT16 -г FAT32 руу хувиргаж болдог. Vvний тулд та хялбархан гvйцэтгэж болох доорх vйлдлийг хийхэд хангалттай.

- Start->Programs->Accessories->System Tools->Drive Converter (FAT32) гэсэн дарааллаар орно.

- Drives гэсэн цонхноос FAT32 руу хувиргах дискийг сонгоно.
- Next товчыг дарсны дараа ОК товчыг дарна.
- Үvний дараа vvcэх цонх тус бvp дээр Next товчлуурыг дарна. Энэ нь 3 удаа давтагдана.
- FAT32 руу хувиргах vйлдэл хийгдэж дууссаны дараа Finish товчлуурыг дарна.

Гэвч зарим компьютерт FAT32 систем таардаггvй гэдгийг анхаарна уу. - Үндсэн хэсгийн төгсгөл -->

Их хэмжээний файл

Галт уулын нэрс ээлжлэн гардаг screen saver тавъя гэвэл Windows системийн vндсэн дэлгэц болох Desktop-оос хулганыхаа баруун товчлуурыг дарж, гарч ирэх цонхноос Properties-г сонгоно. **Display Properties** цонх гарч ирэхэд Screen Saver хэсгийг сонгож эндээс мөн Screen saver гэсэн бичгийн доор байгаа сонголтуудаас 3D Text-г сонгоод Settings товчлуурыг дарна. **Text** гэсний доор байрлах мөрөнд **volcano** гэж бичээд OK товчыг дарна. Vvний дараа screen saver-ээ ажиллуулахад галт уулын нэрсvvд ээлж дараалан гарна.

Систем ачаалах хурдыг сайжруулах

Windows Me - г ачаалахад заримдаа маш удаан хvлээлгэдэг vv? Энэ процессыг хурдасгах хэд хэдэн арга бий. Эхлээд ачаалах veд ямар ямар программ ажиллаж байгааг ажиглах хэрэгтэй. Vvний тулд Start товчийг дараад Run - г сонго. Одоо MSConfig гэж бичээд OK дарахад нилээд олон зvйлийг агуулсан хуудас гарч ирнэ. Yvнээс Startup гэсэн цонхыг сонговол компьютер ачаалах veдээ дуудаж ажиллуулах программуудын жагсаалт гарч ирнэ. Ta аль нэг программын өмнөх нvдэнд байгаа тэмдэглэгээг авсанаар компьютер ачаалах veд тvvнийг ажиллуулахгvй болгож болдог. Зарим программууд нь компьютер ачаалах veд тvvнийг ажиллуулахгvй болгож болдог. Зарим программууд нь компьютер ачаалах veд заавал ажиллах ёстой байдаг. Тэдгээрийг ажиллуулахгvй бол Windows Me - д алдаа өгч болно. Зарим нэг зvйлийг хийхийнхээ өмнө Clean Up товчийг дарж хэрэгцээгvй зvйлvvдээ цэвэрлэж болно. (Windows 98 -д энэ товч байдаггvй.) Хамгийн зөв арга бол хэрэв программыг хаана байрлаж байгааг харуулсан зам C:\Windows байвал тvvнийг хэвээр нь vлдээ. Scan Registry, Load Power Profile, Pointer, Task Monitor ба System Tray зэрэг программууд Windows -д хэрэглэгддэг. Хэрвээ энэ тохиргоонуудыг хийсний дараа систем хэвийн бус ажиллаж байвал энэ vйлдлvvдийг буцааж хийгээрэй.

Модемын тохиргоог хадгалах

Modem settings буюу модемын тохиргоог яаж хялбар хурдан хадгалж болохыг хэлж өгье. Эхлээд Control Panel руу орж Modem гэсэн цонхыг 2 дарж онгойлго. Ингээд Word ч юм уу эсвэл өөр баримт бичиг боловсруулах программыг нээж шинэ хуудас нээ. Тэгээд урьдынхаа нээсэн модемын цонхон дахь Add болон Remove товчноос бусад бүх товч, дэд цонхыг нээнэ. Товч болон дэд цонх болгон дээр нь дарж өөр өөр цонх гарч ирэх бүрт нь *ALT*+ *PRINT SCREEN* товчийг дараад Word руугаа орж PASTE команд өгөн тохируулгуудын зургийг гарган доор нь бага зэрэг тайлбар бичээд түүнийгээ хадгалаарай. Дараа нь таны систем эвдрэх, вирустэх, ямар нэгэн тохиолдлоор ахиж суулгах болоход үүнийгээ харан модемыг тохируулахад хялбар байх болно. Зөвхөн модемын тохиргоо ч биш имэйлийн тохиргоо ч юмуу эсвэл өөр бусад зүйлсийг ч дээрх шиг хадгалан авч болно.

Алга болсон Taskbar -ийг байрлуулах

Өмнө бид Taskbar - ийн хэмжээг яаж өөрчлөхийг тайлбарлаж байсан. Хэмжээг нь өөрчилж байхад заримдаа Taskbar дэндүү жижиг хэмжээтэй болчихдог. Хулганаа дараад ч олддоггүй. Энэ тохиолдолд гарын товчлуур ашиглан Taskbar - ийг байрлуулж үзье. Эхлээд **CTRL + ESC** товчнуудыг дарна. Программын цэсэн дэхь программуудын нэрс хажууд нь гарч ирвэл **ESC** дарахад программийн нэрс алга болох боловч Taskbar идэвхитэй хэвээр байна. Одоо **ALT + SPACEBAR** товчнуудын хослолыг дарвал жижиг цэс гарч ирнэ. Түүнээс Size гэсэн командыг сумаараа сонгоод **ENTER** дарахад курсор дөрвөн тийшээ харсан сум бүхий хэлбэртэйгээр Taskbar дээр харагдана. Хулганыхаа товчийг бүү дар. Харин гарынхаа сум бүхий товчлууруудаар дээш хөдөлгөн түүнийг гаргаж ирж болно.

Notepad дээр мөрийг тэгшитгэх

Notepad текст засварлах программ дээр текстийг өөр файлаас эсвэл вэбээс хуулж оруулж ирэхэд мөрний урт нь Word программ шиг автоматаар тэгшитгэдэггүйг та анзаарсан бизээ. Нэг мөрөн дээр текст бичихэд дараагийн мөр лүү шилжихгүйгээр арагшаагаа үргэлжлээд байдаг билээ. Ийм текстийг хэвлэхэд нэг мөрөн дээр ганцхан үг байгаад дараагийн мөрөнд шилжсэн зэрэг мөрүүд тэнцүү биш харагддаг. Үүнийг засах аргыг одоо хэлж өгье. Notepad программийн **Edit** цэснээс **Word Wrap** -г сонгож дарах хэрэгтэй. Үүний дараа таны хуулж оруулж ирсэн текст эсвэл таны бичсэн текст бүхий мөрнүүд тэгш болно.

Цонхыг хаах

Та хэзээ нэгэн цагт дэлгэц дээрх ямар нэг программийн цонхыг томсгож ч чадахгvй, жижигсгэж ч чадахгvй байх тохиолдолтой учирч байсан уу. Хэрвээ тийм бол энэ цонхыг арилгахын (хаахын) тулд цонхны аль нэг газарт хулганаа дарсны дараа **Alt**, **Spacebar**товчлууруудыг зэрэг дарна. Гарч ирэх цэснээс **Close** -г дарахад цонх хаагдана.

Онлайн холболтын цаг

Имэйлээ шалгах эсвэл Интернэтээс мэдээлэл хайх зэрэгт модемоор холбогдохдоо хэдий хэмжээний хугацаанд орж байгаагаа шалгах шаардлага танд гардаг уу. Хэрвээ тийм бол дараах vйлдлээр тухайн veд холбогдож буй онлайн холболтын цагаа хянах боломжтой. Taskbar дээрээс буюу дэлгэцийн баруун доод өнцөгт байрлах цагний хажууд Интернэтэд холбогдсоныг илтгэх 2 компьютер, утасны зураг бvхий жижиг цонх байдаг. Энэ цонхыг 2 дарснаар та хэдэн минут холбогдоод байгаагаа мэдэх болно.

Файлыг уян диск рvv хялбар аргаар хуулах

Компьютер дэхь файлыг уян диск рvv богино хугацаанд хурдан хуулах аргыг та мэдэх vv. Vvний тулд хуулах гэж буй файл болон файлуудаа сонгоод хулганыхаа баруун товчлуурыг дарна. Гарч ирэх цонхноос **Send To** -г сонгоод **3 1/2 Floppy (A)** -г дарахад файлууд уян дискэнд хуулагдана.

Чухал хэрэгцээтэй файлууд

Нэг директорт хадгалагдаж буй олон файлуудаас чухал хэрэгцээтэй файлаа олох гэж нилээд удах явдал танд тохиолддог уу. Хэрвээ тийм бол vvнийг шийдэх арга байна. Ypгэлж ханддаг хэрэгцээтэй файлынхаа нэрний эхний тэмдэгтийг доогуур зураасаар (_) эхлvvлэн нэрлэвэл Windows Explorer программаас уг директорт ороход файл хамгийн эхэнд нь харагдах болно. Жишээ нь **plan2001** гэсэн нэртэй файл байхад vvнийг _**plan2001** гэж өөрчлөхөд л хангалттай.

Vсгийн фонт суулгах

Vсгийн фонт суулгах нь хэцvv ажил мэт сонсогдовч та өөрөө оролдоод vзвэл хулганаа ашиглан нэг директороос нөгөө директор луу файлуудыг чирч шилжvvлэх мэт vнэхээр хялбар ажил болохыг мэдэх болно. Компьютертаа vсгийн фонт нэмэх нь хэрэглээний

программуудыг суулгахын тулд нэг цонхноос нөгөөд дамжин олон асуултуудад хариулахаас ч хялбар юм. Үсгийн фонтууд нь текст файл шиг маш хялбар зохион байгуулалттай, **C:\WINDOWS\FONTS** директорт байрладаг файлууд юм. Хэрэв vcгийн фонт нь True Type Font байвал (өөрөөр хэлбэл фонтын нэр нь TTF өргөтгөлтэй бол. Жишээ нь ARIAL бол True Type Font учир файлын нэр нь arial.ttf) C:\WINDOWS\FONTS директор луу хуулахад л хангалттай. Ихэнх хэрэглээний программуудад фонт нь дагалдаж ирдэг. Энэ дагалдаж ирж буй фонтын файлуудыг олоод **C:\WINDOWS\FONT** директорт хуулахад шууд ашиглахад бэлэн болно.

Миний компьютер амрах горимд байхдаа гацаад байна

Энэ бол компьютер Suspend буюу амрах горимд байх veдээ гацдаг WINDOWS 98 системийн жижиг алдаа юм. Дараах vйлдлvvдийн тусламжтайгаар энэ бэрхшээлээс гарч болно. Yvнд:

- Start цэснээс RUN -г сонго. Ореп цонхонд msconfig гэж бичээд ОК дар.

- Гарч ирэх цонхноос System.ini -г сонго.
- [386Enh] өмнөх нэмэх тэмдгийг дарж тvvнийг задална.
- PagingFile= гэсэн мөрийг сонгож Edit товчийг дар.
- Жижгээр бичсэн хатуу дискийн vсгийг (с: эсвэл d:) томоор солино.
- Apply товчийг дарна.
- Системээ дахин ачаална.

Системийн зөрчил буюу түүний шийдэл

Та компьютертаа дууны кард ч юмуу ямар нэгэн шинэ төхөөрөмж нэмж суулгалаа. Системийг дахин ачаалсны дараа шинэ төхөөрөмж чинь ажиллахгүй эсвэл өөр төхөөрөмж чинь гэнэт ажиллахаа больсон байна. Энэ нь 2 төхөөрөмж нэг ижил interrupt request (IRQ) дугаартай болчихлоо гэсэн үг. Энэ тохиолдолд аль нэг төхөөрөмж нь ажилладаггүй. Жишээ нь дууны картанд гардаг түгээмэл алдаа нь үргэлжилсэн шүүм (шуугиан) орж ирэх бөгөөд принтерээ унтраах эсвэл хулганаа салгахаас нааш энэ шуугиан зогсдоггүй. Interrupt request тухайн төхөөрөмжийн хийж буй үйлдэл дууслаа гэдгийг процессорт сигнал илгээдэг. Зарим гадаад төхөөрөмж, жишээ нь принтер IRQ- г ашигладаггүй, харин принтерийг холбодог параллель порт нь ашигладаг. Системийн зөрчил байгаа эсэхийг мэдэхийн тулд Control Panel руу ороод System -ийг сонго. Device Manager хэсэг рүү ор. Системийн зөрчилтэй төхөөрөмжийн өмнө шар өнгийн гурвалжин дотор анхаарлын тэмдэг байдаг. Ийм байвал Properties товчыг сонго. Хэрэв та ямар нэгэн зөрчлийг олж харвал та Device Manager сонголтоор ороод IRQ гэсэн товчийг дарвал яг яасан нь харагддаг. Системийн зөрчлийн асуудлыг шийдвэрлэх хамгийн сайн арга бол төхөөрөмжийн инсталлийг устгаж Windows -д өөрөөр нь таниулах боломж олгох явдал юм. Зарим хуучин төхөөрөмжүүд нь өөр дээрээ биетээр тохируулах jumper юмуу switch тэй байдаг. Тийм тохиолдолд та олон янзаар тохируулах гэж оролдох хэрэгтэй болно.

Системийг сэргээх?

Системийн сэргээх функцийн ашиглалтын талаар та нарын зарим нь мэдэхгvй байж болох юм. Энэ функцийг ажиллуулахад маш их цаг хугацаа, хvч хөдөлмөр зарцуулдаг. Хэрэв танд энэ функц хэрэггvй гэдэг нь тодорхой бол Control Panel дахь System -> Performance хэсэгт орж File System -г сонгоорой. Troubleshooting хэсэг дэхь Disable System Restore гэдгийг идэвхжvvл.

Windows-ийн нэмэлт товчлуур

Хэрэв таны компьютерийн гар дээр Windows-ийн зураг бүхий товчлуур байдаг бол энэ нь жирийн гарыг бодвол хэд хэдэн нэмэлт боломжуудтай. Энэ товчлуурын тусламжтайгаар дараах үйлдлүүдийг гүйцэтгэдэг:

WINDOWS+TabTaskbar дээрх товчлуурууд дээр очдог.WINDOWS+RRUN командын мөрийг гаргаж ирэхWINDOWS+FFIND FILES or FOLDERS цонхыг гаргаж ирэхCTRL+WINDOWS+FFind: Computer (to search for a shared computerWINDOWS+EEXPLORER программийг ажиллуулахWINDOWS+MНээлттэй байгаа бvx цонхнуудыг жижигрvvлэх хаахSHIFT+WINDOWS+Mтvр хаасан цонхнуудыг идэвхтэй болгохWINDOWS+F1HELP цонхыг нээнэWINDOWS+BREAKSystem Properties цонхыг нээдэг.

Windows 95, 98 системийг UNINSTALL хийхэд гардаг бэрхшээлvvд

Зарим veд WINDOWS 95, 98, Me хувилбаруудыг uninstall хийх veд бэрхшээлvvд тохиолддог. Uninstall хийх 5 аргын талаар ярилцъя.

Программаас гараад файлуудыг хатуу дискнээс устгана. Энэ бол маш буруу шийдвэр.
 Учир нь программ өөрөө файлуудаа хатуу дискэн дээр хаана байрлуулахаа шийддэг учир

файлуудыг устгаснаас vvcэх ямар нэгэн бэрхшээл гарахыг урьдчилан мэдэх боломжгvй. 2. Программын UNINSTALL процедурыг ашиглах Cvvлийн veд ихэнх прораммууд өөрийн UNINSTALL программтай хамт ирдэг, тvvний тусламжтайгаар таны компьютераас программыг богино хугацаанд хялбархан устгаж болно. Гэвч зарим программууд энэ vйлдлийг иж бvрэн хийж чаддаггvй.

3. Программыг дахин суулгах Зарим veд UNINSTALL хийх хамгийн хялбар арга зам бол програмийг дахин суулгах явдал юм. Үvний дараа программийг устгана. Эсвэл vvнийг 4-р аргатай хамт хэрэглэнэ.

4. Control Panel дахь Add/Remove Programs - ийг ашиглах. Энэ бол Windows систем дэхь программуудыг устгах зориулалтын стандарт хэрэгсэл. Vvний тусламжтайгаар хатуу дискнээсээ программыг ямар ч бэрхшээлгvй устгаж болно.

5. Гуравдагч программын хэрэгслуудийг ашиглах. Norton Uninstall ч юмуу Clean Sweep гэх мэт программууд устгах программд их анхааралтай ханддаг. Ийм программууд өөр ямар ч программтай холбоогуй салангид файлуудыг ч илруулж чаддаг.

CD-ROM, WINDOWS 98 системд гарах хүндрэлүүд

WINDOWS 98 системийг суулгасны дараа CD-ROM ажиллахгүй байх тохиолдол олон гардаг. Ихэнх CD-ROM нь хоёр сувгын буюу dual channel IDE (Integrated Device Electronics) төхөөрөмж байдаг. Windows системд ийм төхөөрөмжинд зориулсан тусгай тохиргоо байдаг. Хэрвээ та ийм бэрхшээлтэй учраад байвал дараах тохиргоог хийгээд үзээрэй:

Start->Settings -> Control Panel гэж ороод System цонхыг 2 дарна. Гарч ирэх дэлгэцээс **Device Manager**-г сонгоод дотроос нь **Hard disk controller** -г 2 дарж орно. Эндээс өөрийн хатуу дискний IDE controller -г сонгоно. Ингээд **Properties** товчлуурыг дараад Settings цонх руу орж Dual IDE channel Settings тохиргооноос **Both IDE Channels Enabled** -г идэвхжүүлээд ОК дар. Дараа нь компьютерээ дахин ачаал.

Setup.exe файлын нэмэлт командууд

Windows ME хувилбарыг суулгах гэж байвал инсталл хийдэг Setup.exe файлын нэмэлт командуудыг мэдэж байхад танд илvvдэхгvй. DOS-ын мөрнөөс өгөх командууд:

/? - нэмэлт командуудыг харуулна

/С - SmartDrive утилитыг дуудахыг болиулна

/d - Одоо байгаа Windows системийн хувилбарыг харгалзахгvйгээр инсталл хийх

/ie - startup disk бэлтгэхийг асуусан дэлгэцийг гаргахгvй байх

/ih - Windows 3.x хувилбараас инсталлыг эхлүүлсэн бол Scandisk ажиллана

/im - low conventional memory буюу санах ойг шалгахгvй

/is -scandisk хийн Хатуу дискийг шалгахгvй байх

/iv - Инсталл хийх явцад системийн онцлогуудыг vзvvлcэн дэлгэцийг харуулахгvй байх /IW - Программийн лицензтэй холбоотой нөхцлvvдийг харуулахгvй байх /T:bob - Windows ME систем дээр "bob" гэсэн директор vvcгэн Temp буюу temporary файлуудыг хадгалах

Компьютерийнхээ хурдыг ихэсгэх

Аливаа нэгэн vйлдэлд бэрхшээл байдгийн адил компьютерт ч бэрхшээлvvд vй олноороо гардгийг та юу эс андахав. Vvний нэг нь хатуу диск билээ. Та хурд ихтэй супер компьютер худалдаж авчихаад тvvндээ хуучин компьютерийнхээ хатуу дискийг шилжvvлэн суулгачихсаны дараа таны компьютер хvссэнээр тань хурдан ажиллахгvй байгаа юм шиг санагдаж байгаа бол vvний гол шалтгаан нь шилжvvлэн тавьсан хуучин хатуу диск юм. Шинэ компьютерийн тань процессорын хурд их байсан ч та бага багтаамжтай хуучин хатуу дискээ тавьсан бол таны процессор хатуу диск pvv хандахдаа удаан байх болно. Хэрвээ та энэ хуучин дискээ ашиглах хэрэгтэй байгаа бол шинэ компьютертэй хату дискээ "Master" буюу анхдагч дискээр тохируулж, хуучин хатуу дискэн дээр тохируулаад дараа нь компьютерийнхээ Setup-аас зааж өгнө.

Компьютерийнхээ хурдыг ихэсгэх

Хэрвээ таны компьютерийн санах ойн багтаамж их ч гэсэн компьютер тань хатуу диск pvvrээ хандаж ажиллахдаа удаан байвал та юуны өмнө сул зайн хэмжээг нь шалгаарай. Хатуу диск дээр *Swap* файл буюу файл буферлэхэд зориулсан зай байх шаардлагатай байдаг. Хэрвээ хатуу дискэн дээр тань хэдхэн мегабайтын сул зай vлдсэн бол Windows систем Swap файл vvcгэхэд зайгvй болж улмаар компьютер тань удаан ажиллахаас гадна файлуудад сөрөг нөлөө vзvvлдэг. Энэ бэрхшээлээс гарахын тулд хуучин, ашиглагддаггvй файл, директоруудыг устгахаас гадна багтаамж ихтэй хатуу диск худалдан авч болно. Эцэст нь зөвлөхөд хатуу дискээ аль болох compression буюу шахахгvй байвал зvгээр.

Run мөрөн дэхь зайтай бичигдэх команд

Танд зарим veд **Run** командын мөрөнд хоорондоо зайтай зvйл бичих шаардлага гардаг уу? Тийм бол яаж засахыг хэлж өгье. *Cool Program* гэж команд өгөхөд Windows систем зөвхөн "Cool" гэснийг команд гэж ойлгох бөгөөд эргээд ийм файл алга байна гэсэн алдааны бичиг гарч ирэх болно.

Vvнийг зөв ажиллуулахын тулд хоорондоо зайтай бичигдэх командыг " хаалтанд бичиж өгөх хэрэгтэй. Жишээ нь 'Cool Program'

Энэ тохиолдолд Windows систем командыг зөв гүйцэтгэх болно.

Компьютерийн хурдыг ихэсгэх

Компьютерийн хурдыг бага боловч нэмье гэвэл дараах зүйлүүдийг хийгээрэй:

 Хэрэглэгдэггvй файл, фонт, программуудыг устгаж цэвэрлэн хатуу диск дээрээ сул зай гаргах хэрэгтэй. Мөн хатуу дискэндээ Defrag хийж энд тэнд замбараагvй хуулагдсан файл, директоруудыг шахах шаардлагатай. Defrag буюу Disk Defragmenter утилитыг ашиглана.
 Санах ойгоо өргөтгөх хэрэгтэй. Үйлдэл хийхэд удаадаг зvйл нь санах ой болохоос <u>CPU</u> биш юм. Санах ойг нэмэгдvvлвэл <u>Windows</u> систем тань хурдан ажиллах болно.

Recycle Bin цонхны нэрийг солих

Windows системийн цонх болох Desktop дээрх ямар ч icon буюу жижиг дүрс бүхий цонхны нэрийг сольж болдог ч Recycle Bin-г сольж болдоггүйг та мэдэх үү? Гэвч үүнийг шийдэх арга зам байдаг. Доорх тохиргоог хийснээр та Recycle Bin гэсэн нэрийг хогийн сав, хогний уут гэх мэтчилэн хүссэнээрээ сольж болдог. Үүний тулд *Start* товчлуурыг даран *Run*-г сонгоод *Regedit* гэж бичэн *Enter* дарна. Тэгээд **HKEY_CLASSES_ROOT** -г сонгоод тэндээс **CLSID** -г сонгоно. Дараа нь {645FF040-5081-101B-9F08-00AA002F954E} гэсэн утгыг 2 дарж тэр дотроосоо ShellFolder -г сонгоод attributes value дээр 2 дарна. 40 01 00 20 гэсэн утгыг 50 01 00 20 болгож солино. Ингээд Desktop дээр байрлах Recycle Bin цонхны нэрийг хүссэнээрээ солих боломж таньд нээгдлээ.

DMA буюу санах ой руу шууд хандах

DMA (Direct Memory Access) -н тусламжтайгаар компьютер дэхь төхөөрөмжүүд болох хатуу диск, CD-ROM зэрэг нь <u>санах ой</u> руу шууд хандах боломжтой болдог. Үүний тулд Та доорх тохиргоог хийнэ үү.

Хэрвээ Таны хатуу диск тань Ultra-DMA төрлийнх бол энэ тохиргоо таарахгүй гэдгийн анхаарна уу!!!

DMA боломжийг төхөөрөмж дээрээ зааж өгөхдөө:

Windows системийн цонх болох Desktop дээрх жижиг дүрс бүхий My Computer цонхыг нэг дарж сонгоод хулганыхаа баруун талын товчийг дарна. Гарч ирэх харгалзах жижиг цонхноос Properties-г сонго. System Properties гэсэн цонх гарч ирэхэд Device Manager-г дараад Disk Drives-г сонгосны дараа өөрийнхөө хатуу дискийг гарч ирэх жагсаалтаас олж 2 дарна. Үүний дараа гарч ирэх цонхноос Settings цэсийг дарж өгөгдсөн сонголтуудаас DMA-г сонго. Үүний дараа Windows 98 системээс анхааруулгын бичиг гарч ирнэ. ОК товчыг дарж гарна. Яг энэ тохиргоог өөрийнхөө CD-ROM дээр хийж болно.

Faster Dialing буюу хурдан холбогдох

Start товчлуурыг дарж Settings -г сонгоод Control Panel дотор орно. Үүний дараа Modems гэсэн цонхон дээр 2 дарахад таны холболтондоо ашигладаг модемын нэр гарч ирнэ. Дараа нь Propertiesтовчыг дарж гарч ирэх цонхноос Connection-г сонгоод Advanced товчин дээр дар. Advanced Connection Settings гэсэн цонх гарсны дараа Extra Settings гэсэн мөрөнд S11=50 гэж бичээд OK товчийг дарж өөрчлөлтийг сануулан гарна. Энэ тохиргоог хийснээр Modem-ноос өгч байгаа зуумэр буюу удаан дуудах дохионы үргэлжлэх хугацааг 100 millisecond байснаас 50 Millisecond болгож богиносгоно.

Illegal Operation

Windows систем болон түүн дээрх хэрэглээний программуудтай ажиллаж байхад тань **Illegal Operation** гэсэн алдаа гарч хэн хүн бүхнийг бухимдуулдгийг Та мэдэж байгаа байх. Энэ асуудлыг шийдэхийн тулд та уг программ байрладаг вэб хуудас руу орж программийн шинэ, хамгийн сүүлийн үеийн хувилбарыг татаж авч суулгах хэрэгтэй.

FAT16, FAT32-ын ялгаа

Таны хатуу дискийн кластерийн хэмжээнээс шалтгаалж FAT нь 32 бит, эсвэл 16 бит гэсэн 2 янзын файл хувиарлах систем байдаг. Хэрэв таны хатуу диск чинь FAT16 битийн кластертай бол та хатуу дискнийхээ нилээд их хэмжээний сул зайг дэмий алдаж байна гэсэн vг. Мөн хатуу диск pvv хандах хугацаа FAT32 -тай харьцуулахад их байдаг. Хэрвээ та 2 GB хэмжээтэй FAT16 системийн хатуу дисктэй бол энэ нь хатуу дискийн кластер бvp 32KB хэмжээтэй байна гэсэн vг. Тэгвэл та энэ хатуу дискээ FAT32 системийнх болгож

өөрчилбөл 1 кластерийн хэмжээ хамгийн бага нь 4KB. Ингэснээр та хатуу дискийн сул алдах зайг 67 хувиар хэмнэнэ гэсэн vг юм. Гэвч зарим компьютерт FAT32 систем таардаггvй гэдгийг анхаарна уу.

Миний Taskbar хаашаа орчихов оо?!?!?

Хэрэв та taskbar-ынхаа хэмжээг өөрчлөж байгаад харагдахгүй алга болгочихсон бол хулганыхаа курсорыг дэлгэцийн хамгийн доод талд шилжүүлэн аваачаад курсор 2 талтай сум болж өөрчлөгдмөгц хулганыхаа зүүн товчыг дараад курсорыг дээшээ зөөхөд таны алга болгосон Taskbar гарч ирэх болно.

CD-г автоматаар ажиллуулагч CDROM Auto-Run команд

<u>CD-ROM</u> төхөөрөмжиндөө ямар нэгэн компакт диск хийхэд <u>Windows</u> vйлдлийн систем vvнийг автоматаар эхлvvлэн ажиллуулдаг билээ. Энэ нь тус дэмтэй ч зарим veд таньд төвөгтэй санагддаг уу?

Хэрвээ тийм бол компакт дискийг автоматаар ажиллуулдгийг болиулах тохиргоо байдаг билээ. Vvнийг тохируулахдаа дараах vйлдлийг хийгээрэй:

Windows системийн ерөнхий дэлгэцээс "*My Computer*" цонхыг сонгоод хулганы баруун товчлуурыг дарж "*Properties*" -г сонгоно. Vvний дараа "*Device Manager*" -г дарж гарч ирэх төхөөрөмжvvдийн жагсаалтаас "*CD-ROM*" -г 2 дарахад таны компьютер дэхь CD-ROM гарч ирнэ. Vvний дараа энэ CD-ROM төхөөрөмжөө сонгоод "*Properties*" товчлуурыг дарж "*Settings*" цэс pvv орно. Эндээс "**Auto insert notification**" гэсний өмнөх чагтыг авч "**OK**" товчыг дарж командыг сануулан гарна. "*Systems*" цонхноос "OK" товчыг дарж гарахад Windows систем Restart хийх эсэхийг асууна.

Принтерт хэвлэх команд өгсөн ажлыг болиулж, устгах

Олон хуудас бvxий ямар нэгэн документыг хэвлэх команд өгсөний дараа болиулах, хэвлэх документынхаа зөвхөн эхний 2-3 хуудсыг хэвлэх гэж байгаад бvx хуудсыг хэвлэх команд өгчихсөн бол vvнийг болиулахдаа *Taskbar* -н баруун талд байрлах принтерийн зургыг 2 дарж ороход жижиг цонх гарч ирнэ. Энэ цонхонд таны хэвлэх команд өгсөн документийн нэр байх бөгөөд vvнийг хулганыхаа тусламжтайгаар сонгон **Delete** товчлуурыг дарж устгана. Эсвэл ерөнхий цэснээс *Printer* -г сонгоод **Purge Print Documents** командыг дарна.
Процессорын болон Интернэтийн холболтын хурдыг шалгах?

Интернэтийн холболтын хурд болон, санах ой, процессорын хурдны хэдэн хувийг ашиглаж байгааг шалгах арга Windows98 системд байдгийг та мэдэх үү? Vvнийг шалгахдаа Start->Programs->Accessories->System Tools -г сонгон орж "System Monitor " командыг дарна. Гарч ирэх дэлгэцний ерөнхий цэснээс "Edit" -г сонгон "Add items" -г дарна. Дараа нь Интернэтийн холболтын хурд эсвэл санах ойн хэмжээг шалгах уу гэдгээс шалтгаалан хvссэнээ сонгож тухай бvрт нь график vvcгэнэ.

System Monitor гэсэн программ байхгvй veд?

Хэрвээ та өөрийн компьютер дэхь процессорын хурд, санах ойн хэдэн хувь нь ашиглагдаж байгааг шалгах гэтэл System Monitor программ байхгvй бол vvнийг суулгах шаардлагатай. Ингэхийн тулд Start->Settings->Control Panel->Add/Remove Programs -г дарж ороод ерөнхий цэснээс Windows Setup -г сонгон System Tools- г 2 дарна. Гарч ирэх сонголтуудаас System Monitor-н өмнөх чагтыг дарж сонгон ОК товчлуурыг дарахад Windows98 системийн инсталл диск асууна. Хэрвээ таньд Windows98 системийн инсталл CD байвал үүнийг уншуулж директорыг зааж өгнө.

Бугдийг сонгох

Windows системд ажиллахад хос товчны vйлдэл хийж тухайн документ дахь бvх мөрийг мөн Windows Explorer дахь бvх файлуудыг сонгож болдог. Vvний тулд та **CTRL** товчыг дарж байгаад '**A**' vcгийг дарах хэрэгтэй. Харин Windows Explorer дээр файлуудыг ингэж сонгохдоо санаандгvй **DELETE** товч дарчихвал сонгосон бvx файлуудаа устгаж болзошгvй тул анхааралтай байгаарай.

DOS горимын дэлгэц

Windows үйлдлийн системээс DOS-ын горимд шилжихэд бүтэн биш хагас дэлгэцээр гардаг билээ. Энэ дэлгэцийг бүтнээр гарч байхаар болгохын тулд **Alt** товчыг **Enter** товчтой зэрэг дарна.

Хэрэггvй файлууд

Таны компьютерын хатуу дискэн дэх 'C:\Windows\Recent' директор дотор хамгийн сvvлд нээж ажилласан файлуудын нэрс байдаг. Хэрэв та хатуу дискэн дэх директоруудаа эмх

цэгцтэй байлгая гэвэл мөн тодорхой хэмжээний зайг суллая гэвэл энэ директор дахь файлуудыг устгаарай. Энэ нь файлын Shortcut буюу зөвхөн файлыг хаана байгааг заасан хуулбар байдаг тул танд айх зvйл байхгvй.

Интернэт дэхь зургуудаас дэлгэцдээ фон хийх

Таныг интернэтээр аялан аль нэг газрын вэб сайт vзэж байхад чинь компьютерынхаа дэлгэц дээр фон болгочихмоор зураг тааралдаж байсан биз ээ. Хэрэв тийм бол тухайн зургыг фон болгох 2 арга байдаг:

1) Та уг зурган дээрээ хулганыхаа сумыг аваачаад баруун талын товчийг дараад гарч ирэх цонхноос "Save as Wallpaper"-г сонгох

2) Тухайн зурган дээрээ хулганыхаа баруун товчийг дараад "Save Picture As" гэдгийг сонгоод зургандаа нэр өгөөд хадгал. Тэгээд Windows системийн vндсэн цонхон дээрээ хулганыхаа баруун товчийг 1 дараад Properties-г сонгоод Background хэсгийг сонгосны дараа 'Browse' товчийг дар. Хадгалсан файлаа олоод ОК товчыг дарж өөрлөлтөө сануулан гарна. Ингэж Wallpaper хийхэд их ой шаарддаг гэдгийг анхаарна уу.

Taskbar дахь холболтын цонх

Зарим хүмүүс Taskbar-ын баруун доод буланд байдаг icon буюу программуудын жижиг дүрс бүхий цонхнуудаас залхдаг. Хэрэв та тэдгээрийн нэг бол Dial-Up Networking программийн холболтын цонхыг Taskbar дээр гаргадаггүй аргыг хэлж өгье. Windows системийн цонх болох Desktop-ooc "My Computer" цонхыг 2 дарж орон "Dial-Up Networking" цонхыг мөн 2 дарна. Үүний дараа таны холболтондоо ашигладаг цонх гарч ирэх бөгөөд энэ цонхыг нэг дарж сонгон хулганыхаа баруун товчлуурыг дарж гарч ирэх цонхноос "Properties" -г сонгоно. Модемны доор байрлах "Configure" товчлуурыг дарж орон ерөнхий цэснээс "Options"-г сонгоод "Status Control" гэдэг үгний доор байрлах "Display modem status" -н өмнөх чагтыг авч ОК товчыг дарж хийсэн өөрчлөлтөө сануулан гарна.

Taskbar дахь чанга яригчын дууг тохируулах цонх

Зарим хүмүүс Taskbar-ын баруун доод буланд байдаг icon буюу программуудын жижиг дүрс бүхий цонхнуудаас залхдаг. Хэрэв та тэдгээрийн нэг бол чанга яригчын дууг тохируулах дүрс бүхий цонхыг Taskbar дээр гаргахгүй байж болдог. Start->Settings->Control Panel гэж ороод Multimedia цонхон дээр 2 дараад ерөнхий цэснээс Audio-г сонгоод '**Show volume control on the Taskbar**'-ын өмнөх чагтыг аваад ОК товчыг дарж өөрчлөлтийг сануулан гарна.

Олон документуудыг нээлгүйгээр хэвлэх

Хэрэв та нэг директор дотор байгаа олон документуудыг нээлгvйгээр хэвлэе гэвэл уг директороо нээгээд хэвлэх гэж байгаа файлуудаа **CTRL** товчыг дарж байгаад хулганыхаа зvvн товчийг дарж сонгоод хулганыхаа баруун товчийг дарж "**Print**" команд өгнө. Танд зөвлөхөд нэг удаад 5-аас илүү файл хэвлэсний хэрэггvй шvv.

Restart Icon

Хэрэв та Windows системийн үндсэн цонх болох Desktop дээрээ компьютерийг шууд Restart хийдэг цонх үүсгэе гэвэл дараах үйлдлүүдийг хийгээрэй. Notepad программ дээр текст файл шинээр үүсгээд дотор нь эхний мөрөнд @EXIT гэж бичээд файлаа EXIT.BAT гэж нэрлээд хадгал. Тэгээд энэ файлынхаа shortcut-г Desktop дээрээ үүсгээрэй. Шинээр үүссэн shortcut -г нэг дарж сонгоод хулганыхаа баруун товчийг дарж Properties-г сонго. Гарч ирэх цонхны ерөнхий цэснээс "Program" -г сонгоод "Close on Exit" гэсэн бичгийн өмнө чагт тавиад "Advanced" товчлуурыг дарж орон "MS-DOS mode" тохиргооны өмнө чагтыг тавьж "Warn before entering MS-DOS mode" тохиргооны өмнөх

чагтыг авч ОК товчыг дарж өөрчлөлтийг сануулан гарна.

Хэрвээ та компьютерээ унтраагаад асаах буюу RESTART хийх шаардлага гарсан үед энэ шинээр үүсгэсэн цонхоо 2 дарахад л болно.

DOS-н горимоос IP хаягаа шалгах

Өөрийн компьютерийн IP хаяг болон дотоод сvлжээний картны MAC хаяглалт зэрэг мэдээллvvдийг DOS-н горимоос шалгаж болдог. Yvнийг шалгахдаа Start->Programs->MS-DOS Prompt гэж ажиллуулан DOS-н горимд шилжсэний дараа командын мөрөнд **ipconfig/all** гэж бичиж өгч *ENTER* дарна.

Том хэмжээний файл

Компьютерт хэрэггvй, том хэмжээний олон файл хадгалагдсанаас дискний багтаамж багасч ажиллагааг хvндрvvлдэг. Энэ бэрхшээлээс тvргэн гарах арга бол мэдээж дискийг хэрэггvй, том хэмжээний файлуудаас чөлөөлж цэвэрлэх явдал юм. Vvний тулд START->FIND->FILES or FOLDERS гэж ороод ерөнхий цэснээс Advanced гэсэн хуудсыг нээ. Энд

39

Та бvx файлаа хэмжээгээр нь ялгаж ангилж чадах ба **At least** гэсэн талбарт файлынхаа хэмжээг зааж оруулна.

Жишээ нь 5000 Кв гэж оруулахад 5000 Кв хэмжээний том файлууд гарч ирнэ. Эдгээр том файлуудаас хэрэггvй гэснээ ялгаж устга. Дахин сэргээх хэрэгцээ гарвал Recycle bin -ээр орж үзэж болно. Чухал шаардлагатай файлаа устгалгvй үлдээж болно.

ТЕМР өргөтгөлтэй файлууд

Windows систем дэх ТЕМР өргөтгөлтэй файлууд нь системийн үйлдлийг удаашруулдаг гэдгийг Та мэдэх үү. Эдгээр файлуудаас болж таны компьютер хэвийн ачааллаж чадахаа больдог. Иймээс хэрэгцээгvй файлуудаа байн байн шалгаж устгаж байх хэрэгтэй. Гэхдээ энэ директорт байгаа файлуудын хэмжээ нь 0 буюу тэгээс их байвал эдгээрийг шалгаж vзэх хэрэгтэйгээс гадна дэд директоруудыг устгалгvй vлдээгээрэй.

Санах ойн сул хэмжээ

Start->Settings->Control Panel гэж ороод System цонхноос нийт санах ойны хэдэн хувь ашиглагдсан болон хичнээн нь сул байгааг мэддэг. Гэхдээ энэ харагдаж буй санах ойн хувь нь тийм ч үнэн байдаггvй. Санах ойны нилээд хэсэг бvрэн ашиглагдаагvй мэт харагддаг. Vvнээс илvv бодитойгоор харуулж болох арга нь Start->Programs->Accessories->System Monitor юм.

Shut Down дэлгэцийг өөрчлөх

Компьютерээ унтраахад Windows системийн Shutdown хийгдэж буй дэлгэц гардгийг та бvxэн мэдэж байгаа байх. Харин энэ дэлгэцийг өөр зургаар сольж болдгийг та мэдэх vv. Shutdown хийгдэж буй дэлгэц нь Windows директор дотор LOGOW.SYS гэсэн нэртэй файл байдаг. Уг файлыг Paint программаар нээж vзэж болно. Уг дэлгэцийг өөрчлөн өөр зураг гардгаар хийе гэвэл зургын файлын хэмжээ нь 320х400 мөн 256 өнгөнөөс илvvгvй байх ёстой. Уг зургынхаа нэрийг LOGOW.SYS гэж өөрчлөөд Windows директор дотор хуулаарай.

Logon цонхыг гаргахаа болиулах

Windows98 үйлдлийн систем ачаалсны дараа танаас нууц үг асуусан "Windows Logon" цонх гарч ирдэг үү. Хэрвээ олон хүн нэг компьютерийг дундаа ашигладаг биш зөвхөн та ганцаараа хэрэглэдэг бол уг нууц үг асуусан цонхыг устгах хэрэгтэй. Ингэхийн тулд Start-

40

>Settings-> Control Panel гэж ороод Network цонхыг 2 дарна. Гарч ирэх цонхноос Primary Network Logon гэсний доор байгаа сонголтуудаас "Windows Logon" -г дараад ОК дарж өөрчлөлтийг сануулна.

Boot хийх хугацааг тургэсгэх

Зарим veд компьютерийг acaacны дараа Windows98 систем aчаалагдахдаа удаан байдаг билээ. Хатуу диск pvv хандаж байгаа дуу гарч, удаж удаж систем aчаалагдан ажлын бэлэн байдалд ордгыг та бvxэн мэдэж байгаа байх. Хатуу диск pvv удаан хугацааны турш хандаж унших нь тvvний эдэлгээнд муугаар нөлөөлдөг учраас зарим нэг огт хэрэглэгддэггvй фонтуудыг устгах хэрэгтэй. Жишээ нь эртний Грекийн фонт байна. Энэ нь нилээд их хэмжээний зай эзэлдэг мөн систем aчаалагдах veэp фонтыг aчаалах гэж нилээд их хугацаа шаарддаг. Vvнийг тэр болгон ашигладаггvй тул устгах нь дээр.

Shut Down хийгдэхгvй байвал яах вэ?

Компьютерийг Shut Down командаар унтраахад зарим veg унтардагтvй. Энэ тохиолдолд ихэнх хvмvvc унтраалгыг нь дарж шууд унтраадаг нь системийн файлуудыг гэмтээх аюултай байдаг. Харин vvний оронд **Ctrl-Alt-Del** товчнуудыг зэрэг дарж, ажиллаж буй идэвхитэй программуудын нэрийг харуулдаг "Task" цонхыг гаргах хэрэгтэй. Ингээд ямар нэг программын ард Not responding гэж гарсан байвал уг программыг хулганы тусламжтайгаар сонгон **End task** товчыг дарж программыг хаана. Байгаа бvx "Not responding" гэж гарсан программуудыг дээрх vйлдлvvдээр хаасны дараа Shut down хийгдэхгvй байвал ахиад командыг өгч компьютерээ унтраана.

Ганц үйлдлээр нээлттэй бүх дэлгэцийг хаах

